



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ-1992 ОН**



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

1992 оны 9...
сарын 1... өдөр

№ 32

Улаанбаатар хот—11
Утас 25976

Нийслэлийн иргэцийн төлөөлөгчдийн анхдугаар хуралдааныг зарлан хийлгэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний учирлагын тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 23 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэцийн Төлөөлөгчдийн анхдугаар хуралдааныг 1992 оны 9 дүгээр сарын 23-ны Лхагва гаригт хуралцуулж цорр дурдсан асууцлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

а/ Нийслэлийн иргэцийн Төлөөлөгчдийн хуралд сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийн тухай;

б/ Нийслэлийн иргэцийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчийг сонгох тухай;

в/ Нийслэлийн иргэцийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн дарга нарыг сонгох тухай;

г/ Нийслэлийн засаг даргад нэр дэвшүүлэх тухай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ДАРГА

ОРЛОГЧ ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД

Л.ЭНЭБИШ

Я.МӨНХЖАРГАЛ

Г.МАНАЛЖАВ

Б.БОЛД

С.ДАНЗАН

Б.ДАШ-ЕНДОН

Х.ДАШЗЭВЭГ

Д.ДОРЖ

Ж.ЗАНАА

Д.МӨНХБААТАР

З.ЦЭРЭВСҮРЭН

Ж.ЭРДЭНЭЧИМЭГ

Хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдийн
1992 оны 9 дүгээр сарын I-ний ху-
ралдаанаар батлав.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АНХДУГААР ХУРАЛДААНЫГ БЭЛТ-
ГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Анхдугаар хуралдаан хийх талаар Хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж тогтоол гаргаж, хэвлэлд нийтлүүлэх.

IX/2 Г.Маналжав

2. Шинээр сонгогдсон төлөөлөгчдийн анкетыг бүрдүүлж, зургийг нь авахуулах.

IX/18-22/IX Төрийн байгуулалтын хэлтэс

3. Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дунг нэгтгэж, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг зөвшөөрүүлэх.

20-23/IX Г.Маналжав
О.Тунгалаг

4. Шинээр сонгогдох хурлын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнийг боловсруулах, намын хэсгийн хуралдаанаар урьдчилан хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах.

20-23/IX Г.Маналжав
О.Тунгалаг

5. Хуралдаанд оруулах илтгэл, тогтоолуудын төслийг бэлтгэх

20-22/IX Г.Маналжав
Төрийн байгуулалтын хэлтэс

6. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүнээр сонгогдсон хүмүүст үнэмлэх, ажлын цэвтрийг хэвлүүлж олгох.

IX/30 Төрийн байгуулалтын хэлтэс

7. Хуралдааны байр, төсөв зардлын тооцоог гаргаж, бэлэн болгох.

IX/20-22/IX Доржсүрэн
О.Тунгалаг
Д.Гомбосүрэн
Хишгээ

8. Хуралдаанд оролцох хүмүүсийн нэрсийг гаргаж, урилгыг хургуулах.

IX/20-22/IX Төрийн байгуулалтын хэлтэс

9. Хуралдаанд оролцогсдыг бүртгэх

23/IX Б.Нарантуяа, С.Оюунгэрэл

10. Саналыг тоолох, нэгтгэж дүнг гаргах

23/IX Очирпүрэв
Оюунбилэ г
Бямбасүрэн
Баатарсүрэн
Т.Туяа

11. Гишүүдэд хоол, хөнгөн зуушаар үйлчлэх

А.Алимаа

12. Хуралдааны протоколыг бичих

23/IX С.Оюунгэрэл
Б.Нарантуяа

13. Хуралдааны явцыг магнитофонд бичих

23/IX Т.Туяа, Туяа

14. Хуралдааны дарга, нарийн бичгийн даргыг албан бичигтэй нь танилцуулах.

22/IX Г.Маналжав

15. Тамгын хайрцаг, хадаг бэлтгэх

санал хураас хэргэс Ю.Гомбосүрэн

16. Хуралдааны материалыг архивлах

24/IX Б.Нарантуяа

Төрийн байгуулалтын хэлтэс

5

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН АНХЛУТААР ХУРАЛДААНД УРИЛ-
ГААР ОРОЛЦОГЧИЙН НЭРС

1. Н.Багабанди-УИХ-ын дарга
2. Д.Гомбожав-УИХ-ын дэд дарга
3. П.Жасрай-Ерөнхий сайд
4. Б.Пүрэвдорж-Тэргүүн шадар сайд
5. Дашцэдэн-УИХ-ын Хурал захиргааны байнгын хорооны дарга
6. Н.Бямбадорж-УИХ-ын гишүүн
7. Ж.Сэрээтэр-Засаг захиргааны дэд сайд
8. Мижид-Засгийн газрын ажилтан
9. Лувсанцэрэн-Засгийн газрын ажилтан
10. Г.Ганхуяг-Хотын АХГЗ-ны тэргүүн дэд дарга
11. Л.Жавзмаа-Хотын АХГЗ-ны дэд дарга
12. Д.Гонгор-Санхүүгийн газрын дарга
13. Ч.Бат-Нийгэм эдийн засгийн бодлогын зөвлөлийн орлогч дарга
14. Д.Баттөмөр-Статистикийн хэлтсийн дарга
15. Л.Доржсүрэн-Цэрэг иргэний хамгаалалтын газрын дарга
16. Ж.Жигжидсүрэн-Материал хангамжийн хэлтсийн дарга
17. Х.Самбаа-Хотын АХГЗ-ны боловсон хүчин
18. А.Сүхбат-Тооцоолох төвийн захирал
19. Д.Найдан-Өмчийн газрын дарга
20. Ц.Чинбат-Хөдөлмөр нийгэм хангамжийн газрын дарга
21. Ц.Мижиддорж-ХААХҮУГ-ын дарга
22. Гомбосүрэн-БХОГ-ын дарга
23. О.Эрдэнэбаатар-Ус суваг ашиглалтын удирдах газрын дарга
24. Н.Аюушжав-Байгаль орчны хяналтын газрын дарга
25. Н.Гаравсүрэн-Цагдаагийн газрын дарга
26. Т.Сарантуяа-Улаанбаатар хотын телевизийн захирал
27. И.Цэрэндулам-Хууль зүйн газрын дарга
28. М.Энхболд-Ахуй үйлчилгээний хэлтсийн дарга
29. Нямсамбуу-Соёл, олон түмний ажлын хэлтсийн дарга
30. Д.Содномзундуй-Спортын хорооны дарга
31. Б.Доржготов-Хотын прокурор
32. Н.Төрбат-Хотын шүүхийн дарга

- 33.Ц.Чогжмаа-Телефон радио ашиглалтын хорооны дарга
- 34.Ж.Октябрь-Худалдаа хоолны ерөнхий компанийн захирал
- 35.Б.Оюунчимэг-Гэрлэх ёслолын ордны дарга
- 36.С.Дагийсүрэн-"Буян" компанийн захирал
- 37.Ю.Цэрэнжав-Монгол лифт компанийн захирал
- 38.Ц.Ванчиг-Хотын урлал чимэглэлийн газрын дарга
- 39.П.Чампин-Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- 40.Ж.Дангаа-Мөн дүүргийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- 41.Ц.Тогтохжаргал-Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн дарга
- 42.Х.Төмөр-Мөн дүүргийн Иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн төлөөлөгчдийн нарийн бичгийн дарга
- 43.Лхамсүрэн-Хан-Уул дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- 44.Ц.Намсрай-Баянзүрх дүүргийн Ардын төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
- 45.З.Норлхоожав-Гачуурт дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
46. Болд-Гачуурт дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
47. Чүлтэмнамдаг-Жаргалант дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
48. Бадарч -Мөн дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- 49.Ц.Алтангэрэл -Туул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- 50.Ч.Оюунчимэг -Багахангай дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- 51.Г.Болд -Хот байгуулалт төлөвлөлтийн газрын дарга
- 52.Т.Жадамбаа -Хотын ерөнхий архитектор
53. Чулуунбат -"Нийслэлийн сонин бичиг" ёонины эрхлэгч
- 54.Л.Гомбожав -Мөн сонин сурвалжлагч
- 55.Ш.Батмөнх -"Ардын эрх" сонин сурвалжлагч
- 56.Ю.Сүхбат -Баянгол дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга
- 57.Х.Булган -Мөн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
- 58.М.Балсанжав -Сонгино дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга

3.

- 59. Д. Дамдинпүрэв - Сонгино дүүргийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- 60. Д. Шатар - "Засгийн газрын мэдээ" сонины сурвалжлагч
- 61. Э. Пүрэвжал - МоАН-ын хотын зөвлөлдөх төвийн дарга
- 62. Ш. Батдэлгэр - МСЦН-ын Хотын зөвлөлийн дарга
- 63. Д. Мөнхбаатар - МУЦН-ын Хотын зөвлөлийн дарга
- 64. Б. Баасанжав - "Улаанбаатар" сонины сурвалжлагч
- 65. Гэрэлсайхан - Мөн сонины сурвалжлагч
- 66. Рэнцэндорж - Улсын Их Хурлын Тамгын газрын дарга

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН МАНДАТЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|-------------------|---|
| 1. А. Данжид | -Төр, нийгэм судлалын академийн
төвийн захирал |
| 2. Ү. Хүрэлбаатар | - "Улаанбаатар" сонины ерөнхий эрхлэгч |
| 3. Г. Маналжав | - Хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдийн
нарийн бичгийн дарга |
| 4. Г. Хорлоо | - 16 дугаар эмийн сангийн эрхлэгч |
| 5. Ж. Оргил | - Сүхбаатарын дүүргийн Ардын Хурлын
Гүйцэтгэх захиргааны ажилтан |

АНХДУТААР ХУРАЛДААН

УЛААНБААТАР ХОТЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН АНХДУГААР ХУРАЛ-
ДААНЫ ДОТООД ЖУРАМ

1. Хотын иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдсон гишүү-
дийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай Мандатын комиссын илтгэл.

2. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч-
дийн дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг сонгох.

Цаг тогтоохгүй

3. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч-
дийг сонгох.

Цаг тогтоохгүй

4. Нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлэх

Цаг тогтоохгүй

5. Хуралдаанаас гарах тогтоолын төслийг хэлэлцэж батлахад

Цаг тогтоохгүй

6. Асуултыг шууд тавьж, хариултыг авна.

Үг хэлэхэд гишүүн бүр эхний удаад 5 минут, 2 дахь удаад
3 минут.

Хуралдааныг 1992 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 9
цагт эхэлж, 2 цаг дутамд 20 минутын завсарлагатайгаар явуулна.
Их завсарлага 13-15 цаг хүртэл үргэлжилнэ.

Намын бүлгүүд шаардлагатай асуудлаар завсарлага авч
болно.

АНХДУГААР ХУРАЛДААН

УЛААНБААТАР ХОТЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН АНХДУГААР ХУРАЛ-
ДААНЫ ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1992.9.23

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай.

Илтгэгч нь Мандатын комиссын дарга

2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг сонгох тухай.

3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийг сонгох тухай.

4. Нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай

АНХДУГААР ХУРАЛДААН

СОНГУУЛИЙН КОМИССЫН ДҮН

1992 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр

№ I

Улаанбаатар хот

Тэргүүлэгчдийн даргыг сонгох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 4 дүгээр заалтыг үндэслэн нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн даргад 2 хүний нэр дэвшиж нууцаар санал хураахад

Санал хураалтанд оролцсон нийт төлөөлөгч 70

хүчинтэй хуудас 70

хүчингүй хуудас -

Тэргүүлэгчдийн даргад нэр дэвшсэн Жигжидсүрэн овогтой Ядамсүрэнгийн төлөө саналаа өгсөн 57, татгалзсан 13, Лувсандамба овогтой Дашнямын төлөө саналаа өгсөн 13, татгалзсан 57

Нийт төлөөлөгчдийн 57 санал буюу 81,4 хувийн саналыг авсан Жигжидсүрэн овогтой Ядамсүрэнг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар сонгож хуралд өргөн мэдүүлж байна.

СОНГУУЛИЙН КОМИССЫН ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.ЧИМЭДОРЖ
Ч.ЭРДЭНЭЧИМЭГ

СОНГУУЛИЙН КОМИССЫН ДҮН

1992 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр

№ 2

Улаанбаатар хот

Тэргүүлэгч гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 4 дүгээр заалтыг үндэслэн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд 9 хүний нэр дэвшин нууцаар санал хураахад санал хураалтанд оролцсон нийт төлөөлөгч 70, хүчинтэй хуудас 65, хүчингүй хуудас 5.

1. Санал өгсөн дүнг нэр дэвшигч бүр дээр гаргавал,

	санал өгсөн	татгалзсан
1. Ж. Эрдэнэчимэг	63	2
2. Г. Өлзий	55	10
3. Б. Цэдэв	55	10
4. А. Цанжид	58	7
5. П. Ганбаатар	55	10
6. Л. Ойдовсамбуу	36	29
7. Л. Гарамжил	48	17
8. Л. Дашням	56	9
9. Ү. Хүрэлбаатар	29	36

2. Хамгийн олон санал авсан доорхи төлөөлөгчдийг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр сонгож өгөхийг хуралд өргөн мэдүүлж байна.

- 1. Ж. Эрдэнэчимэг
- 2. А. Цанжид
- 3. Л. Дашням
- 4. Г. Өлзий
- 5. Б. Цэдэв
- 6. П. Ганбаатар
- 7. Л. Гарамжил

СОНГУУЛИЙН КОМИССЫН ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

(Handwritten signature)
М. ЧИМЭДДОРЖ
Ч. ЭРДЭНЭЧИМЭГ



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН _____ ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН _____ ДУГААР ЧУУЛГАНЫ

ПРОТОКОЛ

1992.9.23

Улаанбаатар, хот

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн анхдугаар хуралдааныг 1992 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 9 цагт МАХН-ын Төв Хорооны байранд хийв.

Хуралдаанд оролцвол зохих 72 гишүүнээс 71 хүн оролцож, ирц 98,6 хувьтай. Өвчний учир ирж чадаагүй хүн 1 байв /Сэр-Од Багануур дүүрэг/.

Хуралдааныг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга Д.Энэбиш нээв /Үгийг хавсаргав/.

Хуралдааны дарга, нарийн бичгийн даргыг сонгох саналыг хэлэлцэв.

Хуралдааны даргаар төлөөлөгч, хотын хянан байцаах хэлтсийн дарга Ж.Хорлоо, нарийн бичгийн даргаар төлөөлөгч, Монгол телевизийн сурвалжлагч Д.Сарангэрэл нарыг сонгож, суудлаа эзлэхийг урив.

Хуралдааны даргаас: Хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулав.

1. Хотын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын гишүүдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай Мандатын комиссын илтгэл.

2. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн даргыг сонгох тухай.

3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийг сонгох тухай.

4. Нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай.

Хэлэлцэх асуудлын талаар төлөөлөгчид санал нэгтэй батлав.

Хуралдааны дотоод журмыг танилцуулахад төлөөлөгчид санал нэгтэй батлав.

Хуралдааны даргаас: Мандатын комиссыг урьдчилж байгуулсныг мэлэгдээд Мандатын комиссын дарга, хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Г.Маналжавыг илтгэл тавихыг

зөвшөөрөв /Илтгэлийг хавсаргав/.

Хуралдааны даргаас: Төлөөлөгч Ишдорж нь Засгийн газрын хуралдаанд асуудал оруулах тул Ишдоржид түр чөлөө өгье.

Төлөөлөгчид зөвшөөрөв.

Намын бүлгийн ахлагчид протоколд нэрээ тэмдэглүүлэхийг хуралдааны даргаас хүссэний дагуу МАХН-ын гишүүдийн бүлгийн ахлагч Х.Магсаржав, МҮДН-ын гишүүдийн бүлгийн ахлагч П.Дашням нар өөрсдийгөө танилцуулав.

Хуралдааны даргаас: Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, нарийн бичгийн даргыг сонгох ажилд орлоо.

✓ Тэргүүлэгч гишүүдийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байх талаар санал оруулж, төлөөлөгч гишүүд дэмжив.

✓ I. Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга Л.Энэбиш нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн даргад Улаанбаатар хотын МАХН-ын Хорооны дарга Жигжидсүрэнгийн Ядамсүрэнгийн нэрийг дэвшүүлж, товч намтрыг танилцуулав.

✓ МҮДН-ын гишүүн, Чингэлтэй дүүргийн төлөөлөгч Ж.Оргил, Тэргүүлэгчдийн даргад Л.Дашнямын нэрийг дэвшүүлэв.

Л.Дашням - Намын итгэлийг хүлээж Тэргүүлэгчдийн даргад нэр дэвшихийг зөвшөөрч байна.

Ж.Ядамсүрэн - Өчигдөр намын бүлэг хуралдаад миний нэрийг дэвшүүлж байгааг зөвшөөрч байна.

Ч.Үржээ - Манай орон зах зээлд эргэлт буцалтгүй шилжлээ. Хүнсний цөөн барааны үнийн хязгаар байгаа. Тиймээс барааны үнэ чөлөөтэй болохыг зөвшөөрч байна.

-Хотод шийдвэрлэвэл зохих хамгийн тулгамдсан асуудал юу вэ?

Ж.Ядамсүрэн - Зах зээлийн жамаар явах учиртай. Амьдралын бололцоогүй айл өрх олон байгаа, чөлөөт үнэнд орохоор ийм хүмүүс хэлмэгдэх юм. Чөлөөт үнэнд шилжих асуудал хоцорч байгаа. Хэрэв чөлөөт үнэнд шилжээд бүтээгдэхүүн нэмэгдэх нөхцөлд үнэ буурна. Энэ асуудлыг би дэмжиж байна.

Л.Дашням - Манай улс шиг нийслэлдээ хэт төвлөрсөн улс байхгүй. Хүн амын хамгийн эмзэг асуудал нийслэлийнхэнд өртөж байгаа. Зах зээлд орлоо гэж ярих боловч яаж орохоо мэдэхгүй байгаа. Хувийн үйлдвэрлэл эрхэлж цаг ээвгүй ажиллаж байгаа хэсэг хүн байгаа боловч түүний хажуугаар бэлэнчлэх сэтгэлтэй

хүмүүс их байна.Зах зээлд яаж орох төв баримжаатай болгоход намууд хамтарч ажиллах хэрэгтэй байгаа.

Г.Буян-Өлзий-Хот үйлдвэржих процесс нийслэлийнхний эрүүл мэдэд их нөлөөлж байгаа.Эрүүл мэндийн хөтөлбөр гаргасан.Энэ хөтөлбөр хэрэгжүүлэхэд хооын удирдлага, хотын хурал их анхаарч ажилласан.Шинэ нэр дэвшсэн дарга нар энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ямар арга хэмжээ авах вэ?

Хотын дарга Л.Энэбишэд энэ талаар авсан арга хэмжээ байгаа учир талархал илэрхийлье.

Ж.Ядамсүрэн-Чуулганд урилгаар оролцож байхдаа энэ хөтөлбөрийг сонссон.Энэ талаар хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

Л.Дашням-Би аливаа зүйлийн сайн талыг өвлөж уламжлуулахыг дэмждэг.Өнгөрсөн хурлынхан энэ талаар нилээд арга хэмжээ авсан.Хурал бол гүйцэтгэх захиргаа биш, бодлого боловсруулах байгууллага,Гэхдээ энэ эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүчин чармайлтаа оруулна.

Ж.Дашдаваа-Материаллаг байдал их буурлаа.Хот хөдөөд ялгаа их гарч байна.Энэ талаар ямар арга хэмжээ авах вэ?

Ж.Ядамсүрэн-Хотод ихэнх үйлдвэр төвлөрч байгаа.Зарим үйлдвэр зогсож байна.Энэнд олон шалтгаан бий.Энэ нь нэг хүнээс шалтгаалаагүй.Эдийн засгийн гадаад бодлогын алдаанаас болж байгаа.Иймээс дотооддоо бие дааж үйлдвэрлэл явуулах хэрэгтэй. I-2 жилдээ хүндрэлээс гарахад бэрх байгаа.Зах зээл гэдэг бол татвар,..... бодлого дээр явагцдаг.Татварын хууль дээр анхаармаар байгаа.

Л.Дашням-Зах зээлд шилжиж байгаа учир эдийн засгийн боломжийг нээх хэрэгтэй.Жижиг үйлдвэр хөгжүүлж байна гэх боловч гол асуудалдаа хөл алдаад байгаа юм шиг байна.Үйлдвэрлэлийг бий болгохын өмнө жижиг зүйлээр наймаа хийж байгаа нь алдаа юм.Зах зээлд хүнд орж байгаа нь урьцах бодлогын алдаа гэдгийг дэмжиж байна.Бид, иргэн бүр улс орноо хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг тооцдог байх хэрэгтэй.Замбараагүй байдал сайн юманд хүргэхгүй.

Ч.Энхбат-Хан уул дүүргийн төлөөлөгч:Нийслэлийн бодлого нь өөрийн гэсэн ямар аястай байх вэ?

Ж.Ядамсүрэн-Нийслэлийн бодлогын явуулахдаа улс орны бодлогоос тасалж болохгүй.Хамт авч үзэх ёстой.

Хүн ам төвлөрсөн учир улс орны бодлоготой хамт авч үзэх хэрэгтэй.

Л.Дашням-Хот, хөдөөгийн нийгэм, завсарын нийгэм гэсэн юм байгаа.Ганц хотын бодлогыг явуулж болохгүй.Гэхдээ хотын онцлогыг тусгаж улс орны бодлого явуулах хэрэгтэй гэж үзэж байна.

Ц.Болдсайхан-Өнөөдөр нийслэлийн хилийн цэсийн асуудлыг УИХ-д оруулах хэрэгтэй.Багануур нь хотод харьяалагдах боловч нутаг дэвсгэр нь Төв аймаг.Нийслэлийн цэсийн асуудлыг УИХ-д оруулахад ямар бодлого баримтлах вэ?

Ж.Ядамсүрэн-Эрдэнэт Дарханыг бие даасан хот болгох талаар УИХ-д тавьсан.Нийслэлийн нутаг дэвсгэрийг шийдэхдээ ХАА,эдэл-бэр газрыг харицах хэрэгтэй.Багануурыг хотод үлдээсэн нь зөв.

Л.Дашням-Хот хөдөөгийн амьдралын харилцаа урьдынхтай адилгүй шийдвэрлэгдэх байх.Багануурыг хотоос салгахгүй, хот маягаар хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Ү.Хүрэлбаатар-Баянзүрх цүүргийн төлөөлөгч Ядамсүрэн даргаас асууя.Та хотын МАХН-ын дарга, тэгээд хотын төрийн удирдагч болох нь.Иймээс таны өгсөн үүргийг МАХН-ынх гэж үзэх үү,хурлын даргынх гэж үзэх үү.Энэ 2 албан тушаалын харьцааг юу гэж үзэж байна вэ?

Ж.Ядамсүрэн-Намын сонгуульт албан тушаал бол намын гишүүдийн итгэл найдвар.Хурлын дарга бол иргэний хувьд хүлээлгэж байгаа итгэл найдвар олон намын системийн үед энэ үүргийг хүлээх эрхтэй гэж үзэж байна.Хуралд ажиллахдаа намын асуудлаар явцуурахгүй.

Хуралдааны даргаас-Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн дагуу 2-оос дээш хүн нэр дэвшвэл нууцаар санал хураах ёстой.

Жигжидсүрэн-Завханы Тариатад багшилж байсны хувьд Ядамсүрэн Дашням нарыг улам судраар нь сайн мэднэ.Парламентад төр тогтлоо.Сонгуулийн ихэнх суудлыг МАХН эзэлж байгаа учир эрх барих намын гишүүн хурлын дарга болж болно.Намын бодлого парламентад онцгой байр эзлэх учир Ядамсүрэн дарга хурлын удирдлагад байх нь зүйтэй.Дашням Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд орж болно.

Хуралдааны даргаас-Өөр санал гаргах хүн байхгүй байгаа учир санал асуултыг таслав.

Ж.Ядамсүрэнг нэрсийн жагсаалтад үлдээе гэж төлөөлөгчид санал нэгтэй батлав.

Л.Дашнямтг нэрийн жагсаалтад үлдээе гэсэн 44 хүн буюу 62,5 хувийн саналтай байна.

Хуралдааны даргаас-Санал хураалтыг I хуудсан дээр хамт явуулах талаар санал хураахад санал нэгтэй зөвшөөрөв.

Л.Энэбиш-Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад Гарамын Маналжавын нэрийг дэвшүүлэв. Г.Маналжавын намтраас танилцуулав.

Ж.Оргил-МҮДН-ын намын бүлэг Г.Маналжавын нэр дэвшснийг дэмжиж байна.

Хуралдааны даргаас-Г.Маналжаваас асуух асуулт байна уу?

Д.Пүрэвдорж-Туул дүүргийн төлөөлөгч

Г.Маналжав дарга Тэргүүлэгчдийн ахуйн хангамж, Хурлын зохион байгуулалтын талаар ямар шинэлэг арга хэмжээ авах гэж байна вэ?

Г.Маналжав-Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулинд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд ажлаа чиглүүлнэ. Энэ удаа ч гэсэн төлөөлөгчид, Тэргүүлэгчдийн идэвх санаачилгаас шалтгаална гэж үзэж байна.

Хуралдааны даргаас-Асуулт, санал шүүмжлэл, таслахыг асуухад төлөөлөгчид санал нэгтэй батлав.

Хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг сонгох тухай тогтоолын төслийг хэлэлцүүлэв.

П.Ганбаатар-Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар сонгох саналаа эхэлж хураагаад тогтоолын төслийг хэлэлцүүлэв.

Хуралдааны даргаас-Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг сонгох тухай санал хураахад 100 хувийн саналтай байв. Тогтоолын төслийг батлуулах санал хураахад тогтоолын төслийг гишүүд санал нэгтэй батлав.

Хуралдааны даргаас-Сонгуулийн комисс байгуулах тухай хэлэлцье. Комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулья гэхэд төлөөлөгчид санал нэгтэй батлав. Сонгуулийн комиссыг танилцуулав.

Бүрэлдэхүүнд өөр санал байхгүй учир төлөөлөгчид санал нэгтэй батлав.

Хуралдааны нарийн бичгийн даргаас-Сонгуулийн комиссыг байгуулах тухай хуралдааны тогтоолын төслийг танилцуулав.

Хуралдааны даргаас-Тогтоолын төслийн талаар санал байгааг асуув.

Д.Пүрэвдорж-Тогтоолын төсөлд албан тушаалыг дурдахгүй, төлөөлөгч гэж дуудъя.

Хуралдааны даргаас-Бүгд төлөөлөгч байгаа учир албан тушаалаар ялгах хэрэгтэй байна.Тогтоолынхоо төслөөр байх талаар санал хураахад 33 хувь, төслийг өөрчлөх санал хураахад 50 хувь саналтай байна.

Хуралдааны даргаас-Сонгуулийн комиссын дарга, нарийн бичгийн даргыг сонгох тухай сонгуулийн комиссын анхдугаар хуралдааны тогтоол уншиж танилцуулав.

Ү.Хүрэлбаатар-Хуралдааны даргаас хуралд төлөөлөгчдийг санал гаргах боломж олгохгүй байна.Төлөөлөгч цотор нам бусчууд байгаа.МАХН, МҮДН-ыг дэмждэггүй бусад намыг дэмждэг хүмүүс байгаа төлөөлөгчид яаж саналаа гаргах вэ?

Л.Энэбиш-Хуулинд заасан цагуу урьдах Хурлын Тэргүүлэгчид анхдугаар хуралдааны ажлыг зохион байгуулах ёстой.Өчигдөр нам бусчуудыг хуралдах байр гаргаж зөвлөсөн.Санал гаргаж болно.

Хуралдааны даргаас-Хуралдааныг шинэлэг байдлаар явуулахад төлөөлөгчдийн өөрсдийн санаачлагаас болно.Нам бусчууд бүлэг байгуулах боломжийг өчигдөр олгосон байна.

Хуралдааны нарийн бичгийн дарга-Сонгуулийн комиссын анхдугаар хуралдааны тогтоолын төслийг танилцуулав.

Хуралдааны даргаас-Сонгуулийн комиссын даргаар М.Чимэддорж, нарийн бичгийн даргаар Ч.Эрдэнэчимэгийг сонгожээ.Сонгуулийн комиссыг ажилцаа орохыг урив.

Сонгуулийн комиссын дарга М.Чимэддорж сонгуулийн дүн танилцуулав.

Тэргүүлэгчдийн даргад нэр дэвшсэн Ж.Ядамсүрэнгийн төлөө саналаа өгсөн 57, татгалзсан 13, Л.Дашнямын төлөө саналаа өгсөн 13, татгалзсан 57 байв.Нийт төлөөлөгчдийн 81,4 хувийн саналыг Ж.Ядамсүрэн авчээ.

Хуралдааны нарийн бичгийн даргаас-Тэргүүлэгчдийн даргыг сонгох тухай хуралдааны тогтоолын төслийг танилцуулахад төлөөлөгчид санал нэгтэй батлав.

Ж.Ядамсүрэн-Өндөр итгэл найдвар хүлээлгэж Тэргүүлэгчдийн даргаар сонгосон та бүхэнд талархалаа илэрхийлье. Хурлын төлөөлөгчдийн итгэл найдварыг хэрэгжүүлэнэ гэдгээ илэрхийлье.

Хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдийн дарга байсан Л.Энэбиш Тэргүүлэгчдийн даргаар сонгогдсон Ж.Ядамсүрэнд Хурлын тамга хүлээлгэн өгөв.

Хуралдааны даргаас-Тэргүүлэгч гишүүнээр 7 хүнийг сонгох санал оруулахад төлөөлөгчид санал нэгтэй батлав. Тэргүүлэгч гишүүдэд нэр дэвшигчдийг Баянгол цүүргийн төлөөлөгч ХТ-ын дарга Б.Отгонсүрэн танилцуулав. Үүнд:

Ж.Эрдэнэчимэг, Г.Өлзий, А.Цанжид, П.Ганбаатар, Л.Ойдовсамбуу, Л.Гарамжил, Б.Цэдэв нар байв.

Ж.Оргил-МҮДН-ын бүлгээс Л.Дашням, Ү.Хүрэлбаатар нарын нэрийг дэвшүүлэв.

Хуралдааны даргаас-Нэр дэвшүүлэх асуудлыг таслав. Тэргүүлэгч гишүүд нэр дэвшсэн Ү.Хүрэлбаатар өөрийгөө танилцуулав.

Танилцуулах асуудлыг төлөөлөгчид санал нэгтэй таслав.

Хуралдааны даргаас-Асуулт хариултын ажилдаа орёо гэхэд төлөөлөгчдөөс асуулт гарсангүй тул асуултаа таслав.

Хуралдааны даргаас- Эдгээр нэр дэвшигчдийг саналын хуудсанд үлдээх талаар санал хураахад Ж.Эрдэнэчимэгийн төлөө 62 хүн буюу 88,6 хувь; Г.Өлзийн төлөө 61 хүн буюу 87 хувь; Б.Цэдэвийн төлөө 57 хүн 81 хувь; А.Цанжидийн төлөө 64 хүн буюу 91 хувь; П.Ганбаатарын төлөө 63 хүн буюу 90 хувь; Л.Ойдовсамбуугийн төлөө 56 хүн буюу 80 хувь; Л.Гарамжилийн төлөө 62 хүн буюу 88,6 хувь; Л.Дашнямын төлөө 66 хүн буюу 94 хувь; Ү.Хүрэлбаатарын төлөө 59 хүн буюу 84 хувь байв.

Хуралдааны даргаас-Энэ 9 хүнээс 7 хүнийг сонгох ёстой. Сонгуулийн комиссыг өөрчлөх санал байгааг асуухад урьдах сонгуулийн комиссыг хэвээр ажиллуулъя гэв.

Т.Энхтайван-Засаг даргын сонгуулийг хамт явуулъя.

Хуралдааны даргаас-Засаг даргын сонгуулийг тусад нь явуулах талаар төлөөлөгчдөөс санал хураахад 69 хүн зөвшөөрч 1 хүн татгалзав.

Тэргүүлэгчдийн дарга төлөөлөгч гишүүдэд гишүүний үнэмлэх гардуулав.

Хуралдааны даргаас-Сонгуулийн комиссыг ажилдаа орохыг урив. Санал хураах ажилдаа оров. Сонгуулийн дунг комиссын дарга

М.Чимэддорж танилцуулав.

Ж.Эрдэнэчимэгийн төлөө 63 хун, Г.Өлзийн төлөө 55 хун, Б.Цэдэвийн төлөө 55 хун, А.Цанжидын төлөө 58 хун, П.Ганбаатарын төлөө 55 хун, Л.Ойдовсамбуугийн төлөө 36 хун, Л.Гарамжилийн төлөө 48 хун, Л.Дашнямн төлөө 58 хун, Ү.Хүрэлбаатарын төлөө 29 хун санал өгчээ.

Хүчинтэй хуудас 65, хүчингүй хуудас 5 байв.

Ж.Эрдэнэчимэг, А.Цанжид, Л.Дашням, Г.Өлзий, Б.Цэдэв, П.Ганбаатар, Л.Гарамжил нар олонхийн саналаар Тэргүүлэгч гишүүнээр сонгогджээ.

Хуралдааны нарийн бичгийн даргаас Тэргүүлэгчдийг сонгох тухай тогтоолын төслийг уншиж танилцуулахад төлөөлөгчид санал нэгтэй батлав.

Хуралдааны даргаас нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүнээр сонгогдсон төлөөлөгчдөд баяр хүргэж ажлын амжилт хүсэв.

Хуралдаан 13 цагт түр завсарлав.

Хуралдаан үдээс хойш 15 цагт эхлэв.

Хуралдааны даргаас: -Нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлэх ажилдаа орьё гэв.

Хотын МАХН-ын Хорооны дэд дарга, Төлөөлөгчдийн МАХН-ын бүлгийн ахлагч Х.Магсаржав хотын Засаг даргад хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны дэд дарга Ц.Баасанжавын нэрийг дэвшүүлж, түүний намтраас танилцуулав.

Л.Дашням: -МУДН-ын бүлэг МАХН-ын оруулж байгаа саналыг цэмжижи байна.

Хуралдааны даргаас: -Засаг даргад нэр дэвшүүлэх асууцлыг таслая. Ц.Баасанжаваас асуух асуултанд орьё гэв.

Ж.Базаррагчаа: -Малын бэлчээр хадлангийн асууцлыг яаж шийдэх вэ? Хорооны бүтцийг тогтооход Засгийн газрын саналыг яагаад тусгаагүй вэ? Хөдөлмөрчдийг юу бухимдуулж байна, яаж шийдэх вэ?

Ц.Баасанжав: -1991 оны тооллогоор малтай иргэд болон малын толгой нэмэгдсэн. Амьдрал явагдаж байгаа талбай гэвэл 430 мян.га байгаа. Хотын цэсийн асууцлыг засгийн газарт оруулсан УИХ шийдэх байх.

2.Хүн амын үйлчилгээнд /хүнс, цахилгаан, дулаан тээврийн/ хүндрэл гарч байна. Хотын хангамж төр засгийн хараанд байх ёстой.

Хөрөнгө, машин тоног төхөөрөмжөөр гачигдаж, бараа таваар нийлүүлэгдэхгүй байгаа 3 зүйлийг үндэс болгож байна. Манай улс зах зээлд эргэлт буцалтгүй шилжиж байгаа учир улсын өмчийг задалж хувьчлах хэрэгтэй. Дүүрэгт хороо бий болгох асуудалд би оролцоогүй. Хороог дүүргийн засаг дарга мэднэ. Харин цалингийн фондыг нийслэлийн засаг дарга мэднэ. I/I хүртэл хорооны орон тоог цалинжуулах боломж бий гэж үзэж байна.

Ж.Эрдэнэчимэг-Баянгол дүүргийн төлөөлөгч эмэгтэйчүүд зах зээлийн нөхцөлд хүнд байдалтай тулгарч байна. Иймээс амьдралын бололцоогүй эмэгтэйчүүдийн талаар ямар арга хэмжээ авах вэ?

Ц.Баасанжав-Ажилгүйчүүдийн 60 хувь нь эмэгтэйчүүд байгаа. Эмэгтэйчүүдийн цаана үр хүүхэд байгаа. Эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах гэр орондоо хөдөлмөр эрхлэх боломжоор туслана.

Ч.Сангарагчаа-Хан-уул дүүргийн төлөөлөгч:

1. Сахилга дэг журмыг бэхжүүлэх талаар юуны өмнө ямар ажил хийх вэ?

2. Цагдаагийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэх талаар ямар арга хэмжээ авах вэ?

Ц.Баасанжав-Сүүлийн үед сахилга дэг журам суларч гэмт хэрэг өсөж байна. Хэрэв засаг дарга болбол сахилга суларч байгаа шалтгааныг судалж ажлаа чиглүүлнэ. Үндсэн шалтгаан гэвэл ажилгүйдэл, нийгмийн бүх салбарт хүмүүсийн сэтгэл санаа хямарч, тогтворгүй байдал, архидалт, хууль хяналтын байгууллагуудын ажлын хариуцлага суларч байна. Иймээс цараах арга хэмжээг авна. Үүнд:

Ажлын байраар хангах, торгуулийн системийг өөрчлөх, албан газруудын хяналт хамгаалалтыг сайжруулах, цагдаагийн байгууллагыг машин техникээр хангах, төрийн байгууллагын ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх асуудлууд юм.

А.Зул-Сүхбаатар дүүргийн төлөөлөгч

Шинэ дүүргийн хүн амын үйлчилгээний талаар ямар арга хэмжээ авах вэ?

Шинэ дүүргийн талаар арга хэмжээ авна. Чингэлтэй дүүргийг ОСНАА-н II кэшторт, Сонгино дүүргийг АА-ийн 022-р ангиас авсан байранд оруулах саналтай байгаа.

Ү.Хүрэлбаатар-Баянзүрх дүүргийн төлөөлөгч Улаанбаатар сонинд гарсан төр захиргааны байгууллагын ажлын шүүмжлэлд яаж хандах вэ. УБ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүдийн ажлыг уялдуулах талаар ямар ажил хийх вэ?

Улаанбаатар сонинд хотын ажлыг шүүмжлэхийг хүлээж авна. Энэ нь төр, иргэдийг холбох үзүүр юм. Төр засгийн бодлогыг Улаанбаатар сонин барьж ажиллах нь зүйтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгслэлийг нэгтгэх ажлын хэсгийг холбогдох байгууллагуудтай зохицож болох байх.

Ч.Үржээ-Өвчлөл их байна. Пүүс хоршооллууд ажлын нөхцөлгүй байранд ажиллаж амьдарч байна. Энэ асуудлыг шийдэх талаар ямар арга хэмжээ авах вэ. Хотын АЦХСС татан буугдах нь хэр үр дүнтэй гэж та үзэж байна. Зах зээлийн нөхцөлд төрийн зохицуулалт чухал гэж ярьж байна. Төрийн зохицуулалтын ямар аргууд байж болох вэ.

Ц.Баасанжав-Хот хогондоо царалдсан асуудал гэрийн хорооллуудад их байгаа. Энэ нь хэд хэдэн үндсэн шалтгаантай. Бензин шатахууны асуудал. Хэрэгцээт бензин, шатахууны 40 орчим хувийг олгож байна. ТҮ-ний трестүүдийн хог тээвэрлэдэг машин хүрэлцэхгүй, сэлбэгээр сууж байгаа. Хот тохижуулах байгууллагууд санхүү эдийн засгийн хувьд бэрхшээлтэй байна.

ОС-ны хороололуудын подвалд дэлгүүр, аж ахуйн нэгж, үйлчилгээний байгууллагууд их орсон. Энэ асуудлыг 5-р сараас эхлэн журамлаж байгаа. Боломжтой заримд нь ажлын байр гаргаж өгч байгаа. Үзлэг шалгалт хийж байна. Байшингийн I давхруудыг боломжтой хэмжээгээр суллаж, үйлчилгээний зориулалтаар ашиглахаар зарим ажлыг эхлэн хийж байна. Ашиглагдаж байгаа үйлчилгээний байгууллагын талбай бүрэн гүйцэд ашиглуулах бодлого барьж ажиллана.

С.Батдорж-Налайх дүүргийн төлөөлөгч 12 дүүрэг зах зээлийн нөхцөлд хотоос төвлөрсөн хангамжтай байх нь ямар бэ? Зарим нэг дүүргийг чөлөөт бүс болгож болдоггүй юм уу? Тухайлбал: Налайх дүүрэг энд дэд бүтэц сайн хөгжсөн. Төмөр зам, онгоцны буудалтай. Налайхын 27 мянган хүнд ахадсан байгаа.

Ц.Баасанжав-Энэ бол чухал асуудал. Нийслэлийн захын дүүргийг би даалгуулах, дагуул хот болгох асуудлыг судлана. Багахангайг нээлттэй бүс болгож тэнд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх ажлыг эхлэж байгаа. Тэнд Финланд улстай хамтарч махны үйлдвэр байгуулж байгаа. Багануур, Налайх, Багахангай дүүргүүд биеэ дааж ажиллаж байгаа. Гэхдээ бие даалгаж байна гээд хотын удирдлагаас салгахгүй хотын дүүрэг хэвээр байна.

Д.Нямсүрэн-Багануур дүүргийн төлөөлөгч-Багануур нь УБ хотоос нилээд алслагдсан учир хотод явагдаж байгаа ажил, үйл явдлууд

тэр болгон хүрч чаддаггүй. Тухайлбал: Нийслэлийн телевизийн нэвтрүүлэгийг үзэж чадахгүй байна. Малтай иргэдэд бэлчээр, талбай хүрэлцэхгүй байна.

Ц.Баасанжав—I дэх өдрийн бие даасан нэвтрүүлгийг Налайх, Багануурын хөдөлмөрчдэд үзүүлэх асуудлыг цаашид шийдвэрлэж болно. Энэ асуудлыг судлаж үзэхийг "Өлзий" пүүсийн захирал Сарантуяад үүрэг өгсөн. II дахь асуултанд би түрхүүн хариулсан.

Ч.Энхбат—Нийслэлийн уугуул иргэдийн тээг гаргаж болохгүй юу?

Ц.Баасанжав—Энэ асуудлыг би урьд сонирхож байгаагүй.

Д.Пүрэвдорж—Туул дүүргийн төлөөлөгч—Хотын гүйцэтгэх захиргаа, дүүргүүдийн аппаратын орон тоо ямар байх вэ?

Бие даасан дүүргүүдэд эдийн засгаа дагаж мал өсгөх асуудал арай өөрөөр тавигдах болов уу?

Захын хорооллуудад өөрийгөө хангах талхан цөх ажиллуулж болохгүй юу? Ийм цөхтэй дүүргүүд хэд байна вэ?

Хэвлэлийн шүүмжлэл: Таны удирдлагад байсан ОС тасгийн дарга Лхагвасүрэнг хэвлэл мэдээллээр их ярих боллоо. Үүнд та яаж хандаж байна.

Ц.Баасанжав—Хот, дүүргийн гүйцэтгэх захиргааны аппаратын орон тоо энэ жилийн хувьд шийдэгдсэн. Цаашдаа нарийвчлан авч үзнэ. Нийслэл хот өөртөө байгаа бололцоо боломжийг муу ашиглаж байна. Талхан цөх байгуулах боломж бий. Миний удирдлагад ажиллаж байсан Лхагвасүрэнгийн асуудлыг радио, хэвлэлээр ярьсан хэмжээнээс илүү ойлголтгүй байгаа. Хүний нь хувьд би харамсаж байна. Биеийн нь дааж ажиллуулах зарчим баримталж байсан.

Хуралдааны даргаас—Асуулт хариултыг таслахыг хэлэлцүүлж батлуулав. Ингээд төлөөлөгчид үг хэлэх ажилд оров.

Л.Дашням—Баасанжав даргад хэлэх үг байна. Дээд талын хүмүүстэйгээ тоомжиргүй ханддаг гэж шүүмжилдэг юм билээ. Аль ч намтай ажил харьцаж хамтарч ажиллана байх гэж боцож байна.

Г.Буян—Өлзий:—Сонгино дүүргийн байршил зохимжгүй юм. Гэр хороолол их, усан хангамж, хүн амын үйлчилгээ хэцүү байгааг харж үзэх. Энэ талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах. Янхануудын талаар албан ёсны бүртгэлтэй болж хяналт тавьж ажиллах хэрэгтэй байна. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад 100 байр өгнө гэснээ хэрэгжүүлнэ байх.

Д.Пүрэвдорж-Аппараттайгаа ажиллах талаар+эхлэх хэрэгтэй. Ажлаа
Ялангуяа ажлын холбоо байгаагүй хэлтэстэй ажиллах.ШБОС, шинж-
лэх ухааны ололтыг дэмжих талаар хотын АХГЗ хойрго байдгыг
анхаарах.Хариуцах ажилтаныг ч авч үзэх.Иргэдтэй тулж ажилладаг
хороодын цалинг нэмэгдүүлэх, ажлыг нь зөв үнэлж дүгнэх хэрэгтэй.
Боловсон хүчнийг зөв сонгож ажиллуулах хэрэгтэй.Боловсон хүчний
байршлыг зөв авч үзэхэд анхаарах.

Л.Парамжил-Гэмт хэрэг өсч согтуугаар их танхайрч байна.
Хүмүүсийн бухимдал их байна.Жудаггүй хулгайч их байгаа.Энэ
асуудлыг шийддэг цагцаа нар маань сүүлийн 2 жил хувцасаа солио-
гүй, унаагүй, хоолгүй байна.Иймээс олигтой нь манайхаас гараад
алга боллоо.Зан аашаа зохицуулж ажиллах хэрэгтэй.

Ч.Энхбат-Хан уул дүүргийн төлөөлөгч-Улаанбаатар хотын
ууган хүмүүс гэж байхгүй болсон юм шиг байна.Энэ асуудлыг ганц
засаг даргадаа биш, засгийн газарт ч хэлэх гэсэн юм.Ихэнх нийс-
лэлийнхэн нутаг явж амардаг.Мал хувьчилж авч байна.Хотоц мал
байх хэрэггүй байх.Нийслэлээ улсын төв шиг болгож хөгжүүлэх
хэрэгтэй.Нийслэлийн унаган иргэдийн талаар судалгаа байхгүй
юм шиг байна.Унаган иргэдэд хувьчлалаар олгох юмгүй болж байна.

Хуралдааны даргаас-Санал шүүмжлэлийг таслах талаар хэлэл-
цүүлэхэд төлөөлөгчид санал нэгтэй таслав.

Ц.Баасанжавыг Засаг даргад нэр дэвшүүлэх талаар санал авахад
төлөөлөгчид санал нэгтэй нэр дэвшүүлэв.Хуралдааны нарийн бичгийн
даргаас нийслэлийн засаг даргад Ц.Баасанжавыг нэр дэвшүүлэх
тухай тогтоолын төсөл уншиж танилцуулахад төлөөлөгчид санал
нэгтэй батлав.

Хуралдааны даргаас-Засаг даргад нэр дэвшсэн Ц.Баасанжавд
баяр хүргэж, ажлын амжилт хүсэв.Хуралдааныг хааж үг хэлэв.
/Үгийг хавсаргав/

УИХ-ын орлогч дарга Д.Гомбожав

Хуулинд зааснаар Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд
нийслэлийн хөдөлмөрчдийн эрх ашгийг хөндсөн бүх асуудал хамаарна.
Хурлын шийдвэрийг сурталчлах, хуралд таслах эрхтэй оролцох, асуу-
дал боловсруулж оруулах эрхтэй.Хурлын чөлөөт цагт түүний тэр-
гүүлэгчид ажиллана.

Монгол орны байдал маш хүнд эдийн засаг уналтанд орлоо. 2 сая хүн, 25 сая малтай, Улсын санд төгрөг, валют байхгүй. Ард түмний аж амьдралыг дээшлүүлэхэд цаг хэрэгтэй. Энэ хугацааг богиносгоход та бүхний үүрэг их. Засгийн газар мөрийн хөтөлбөрөө боловсруулж УИХ-д өргөн барив. Ээлжит бус хуралдаан 25/IX-нд болж I. Засгийн газрын мөрийн хөтөлбөр

2. Сахилга дэг журмыг бэхжүүлэх тухай хэлэлцэнэ.

Нийслэлд оюуны болон эдийн засгийн асар их чадамж бий. Иргэдийн идэвх санаачлага зарим талаар сул байна. Сүүлийн 2 жилд хулгай, танхайн хэрэг маш их өслөө. УИХ, Засгийн газарт иргэдээс их захидал ирж байна. Сахилга дэг журмыг бэхжүүлэх асуудал чухлаас чухалд тавигцаж байна. Зарим хуулийн заалтанд өөрчлөлт оруулах. Шинээр хууль гаргахыг хүлээлгүүгээр зарим асуудлыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Энхтайвны өргөн чөлөөний гудамжны дэг журамтай холбоотой асуудлаар Тарамжил, Ганхуяг нартай ярьж зарим үүргийг өгсөн. Дамын наймаа хийх, архи дан согтуурах явдал нийслэлийн гудамжинд их гарах боллоо. Ил бие засах, хог новш тарих, замын хашаа хаалт эвдэх явдал их гарч байна. Юуны өмнө хүнс барааны захыг олшруулах. Дүүргүүдэд зах нээх. 37-р авто бааз гээд том хашаатай газрыг ашиглах. Стадионы хойд талын үзэсгэлэн гаргадаг байрыг ашиглаж болно. Зөвлөлтийн цэргийн ангиудын байр савыг бүрэн цүүрэн ашиглахгүй байна. 50 гаруй мянган өндөр настан байдаг. Эдгээрийн хүчийг ашиглах. Төр засгийн бодлогыг ярьж таниулдаг ухуулагчтай болмоор байна. Үнэмлэх олгож тодорхой хэмжээний урамшуулал өгч байх. Хог хаях, хот тохижуулах ажилд хяналт тавиулах постоор өндөр настнуудыг ажилдуулж торгуулийн орлогын дийлэнх хувийг өөрт нь олгох. Гэл нь тасалбарын хуудастай болгох хэрэгтэй.

Улаанбаатар хотыг яаж хүнсээр хангах вэ? гэдэг асуудал дээр ярья. Одоогийн сүүгээр хангаж байгаа Төв, Сэлэнгийн сүүний фермд ганц найдаж болохгүй. Эдгээр фермийн техник, технологи хоцорсон. Үнээний тээвэр цөөрч, сүүний гарц нь муудсан. Сүүгээр хангахын тулд үнээний үүлдвэрийн сайжруулах. /ХХҮЯ-нд санал тавих/ /Америкаас үнээ авах/ Улаанбаатар хотод 10-15 үнээтэй энгийн фермүүдийг байгуулах. Гадаацаас хуурай сүү авах ногооны хувьд нарийн ногоогосор өөрөө өөрийгөө хангах бололцоо бий.

50-100 Солонгос, Япон урьж ирүүлж залуучуудыг цагуулж ажиллуулах. Улаанбаатар хотын шууд харилцаатай хотууд байна. Үүнтэйгээ хамтарч ажиллах.

Махны хувьд: 5 хошуу малаар махны хэрэгцээ хангахгүй. Тахай, шувуу, тахиаг үржүүлэхэд онцгой анхаарах.

Нийслэл хотыг хөгжүүлэхэд хөрөнгийн их үүсвэр бий. Үүнийг түрүүчийн гүйцэтгэх захиргаа муу ашиглалаа. Оршин суугчдаас авах татвар байна. Нэг иргэнээс 2 төгрөг авахад жилд 1,2 сая төгрөг хуримтлагдана. Хувийн машинтай хүмүүсээс татвар авах. Баянзүрхийн товчоог ашиглаж гарч, орж байгаа тээврийн хэрэгслэлээс татвар авах гэх мэт санах юм их байна.


Хот, дүүргийн гүйцэтгэх захиргааны аппаратыг бэхжүүлэх талаар яриа хийж, ойрын үец хийх ажлаа ярих. Хурлын Тэргүүдэгчид, Засаг даргаас урьдчилан ярих зүйлээ тохиролцох.

Улаанбаатар телевизийн нэвтрүүлгийг өргөн ашиглах. Телевиз, радио, сонинны редакцийн хамтарсан зөвлөл байгуулах асуудал зөв. Төр засгийн шийдвэрийг сурталчлах хэрэгтэй. Аппаратад шинэчлэл хийхдээ аппаратаа црмхон, чанартай болгох. Улсын Их Хурлын намын чуулганыг 13/Х -нд хийнэ. 20-иод хууль хэлэлцэнэ.

Өмчийн талаар хяналт тавьдаг байгууллага алга боллоо. Үүнийг бодох ёстой асуудал. Ингээд та бүхэнд ажлын амжилт хүсье.

Хуралдаан 17 цаг 10 минутац дуусав.

ХУРАЛДААНЫ ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ж. ХОРЛОО
Д. САРАНГЭРЭЛ

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
АНХДУГААР ХУРАЛДААНЫ АЖИЛЛАГААГ НЭЭЖ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ТЭРГҮҮ-
ЛЭГЧИД, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ЦАРГА НӨХӨР
Л.ЭНЭБИШИЙН ХЭЛСЭН ҮГ

Төлөөлөгч нөхөд өө!

Монгол улсын Үндсэн хуулийн дагуу орон нутгийн Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль батлагдан гарч, түүнийг хэрэгжүүлэх ажил явагдаж байна.

1990 онд болсон чөлөөт ардчилсан сонгуулиас хойш яг хоёр жилийн хугацаа өнгөрлөө. Энэ сонгуулиар хотын Ардын Хуралд МАХН, МоАН, МУДН, МСДН-ын гишүүдээс бүрдсэн 151 депутат сонгогдож сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд нийслэлийн төр захиргааны байгууллагыг удирдаж ажиллалаа.

Хотын Ардын Хурал, гүйцэтгэх захиргаа нь өнгөрсөн хоёр жилд улс оронд өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийг гүнзгийрүүлж, ардчилал, хүний эрхийг дээдлэх талаар багагүй ажлыг хийлээ.

Парламентад суудалтай дөрвөн намын төлөөлөгчдөөс бүрдсэн хотын Ардын Хурал, түүний тэргүүлэгчид нь сонгуулийн хугацаанд нийслэлийн хурал захиргааны байгууллагын үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах, нийслэлийн эдийн засаг, нийгмийн амьдралыг тогтворжуулах, хүн амыг хүнсний зүйлээр байгаа боломж, бололцоондоо түшиглэн хангах бүхий л хүч анхаарлаа төвлөрүүлсэн юм.

Хотыг зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжүүлэх бүхэл бүтэн погчолбор асууллыг чуулганаараа тусгайлан хэлэлцэж өмч хөрөнгийг эзэнд нь ойртуулах, бага хувьчлалыг шуурхай явуулах арга хэмжээг авлаа.

Үүний үрээр худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ зэрэг салбаруудын өмч хувьчлалыг бүхэлд нь явуулж хотын эдийн засгийн бүтэц, тогтолцоо өөрчлөгдөж байна.

Энэ ажлын хүрээнд 603 аж ахуйн нэгжийн хөрөнгийг бага хувьчлалд хамруулж 601,5 мянган ширхэг ягаан тасалбар, 33,6 сая төгрөгөөр худалдаж 115 байгууллагыг их хувьчлалд оруулаад байна.

Нийслэлийн нийт хүн амын 68 хувь буюу 331,5 мянган хүнд хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгосны дотор тахир дутуу, амьдралын түвшин дорой 37,9 мянган хүнд үнэгүй олголоо.

Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаа энэ үед үйлдвэр, үйлчилгээний газар түүхий эд, сэлбэг материалаар тасалдаж, ажилгүйчүүдийн тоо өсөж, чөлөөт үнийн тогтолцоо бий болж хүн амын амьжиргааны төвшин буурч байгаагаас өрхийн нэг хүнд оногдох орлогын төвшингөөс доогуур айлын тоо нэмэгдсээр байна.

Энэ бүхэн нь нийслэлийн Хурал, захиргааны байгууллагаас зохих ажлыг өөрчлөх, авах арга хэмжээг шуурхай болгохыг зүй ёсоор шаардаж байна. Өнгөрсөн сонгуулийн эрхийн хугацаанд хотын захиргаанаас нийт 35,3 сая төгрөгийн тэтгэвэр, тусламжийг 35 мянга гаруй иргэнд олголоо.

Олон амбүлтэй айл, өндөр настан, өнчин зэрэг амьдралын гачигдалтай 618 иргэнд орон сууц олгов. Энэ бүхэн нь нийслэлийн хүн ардын аж амьдралд зохих нөлөө үзүүлж байгаа боловч өлссөн, даарсан, өвдөж зовсон, орлогогүй, ах дүү, харж асрах хүнгүй иргэний тоо буурахгүй байгаа нь бидний сэтгэлийг зүй ёсоор эмзэглүүлж байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед нэгдсэн хуваарилалтаар хангаж байсан хүнсний хангамж өөрчлөгдлөө. Зургаан зуун мянга шахам хүн ардын хүнс хоолны хангамжийг хот өөрөө бие даан хангахад бүхий л боломжоо дайчлан ажиллав. Ингэснээр нийслэлийн хүн ардыг мах, гурил, төмс, хүнсний ногоо, сүү зэрэг өдөр тутмын хүнсний бүтээгдэхүүнээр бүрэн хангаагүй ч гэсэн таслахгүй байх талаар зохих арга хэмжээ авч байна.

Хүн амын дотор өрнөж байгаа туслах аж ахуй эрхлэх, мал өсгөх санаачлагыг бүх талаар дэмжиж байгаагийн үр дүнд малын тоо өсөж, сүүлийн хоёр жилд 600 гаруй га газрыг төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах хүсэлтэй иргэдэд олгов.

Нийслэлийн иргэдийн ахуй амьдралыг дээшлүүлэх, өтөрийн хууль тогтоомжийг сурталчлан хэрэгжүүлэх, сахилга дэг журмыг бэхжүүлж, Цагдаа, шүүх, хяналтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар хотын Хурал, захиргаанаас өнөөгийн хэцүү үе байгаа ч гэсэн өөрийн боломжийн хирээр ажиллаж ирлээ.

3.

Улс оронд тохиолдож байгаа бэрхшээл нь нийслэлд бүрч тэд мэдрэгдэж байдаг юм. Бэрхшээл, дутагдал бүрийг лаван туулж, хөтөө хөгжүүлэх, хүн ардаа зүй зохистой амьдруулах, нийгэм соёлын бүх салбарыг жигд ажиллуулахад хотын Ардын Хурлын депутатууд, дөрвөн намын элч төлөөлөгчдөөс бүрдсэн Тэргүүлэгчид өөртөө байгаа хүч чадал, идэвх санаачлагаа бүрэн дайчлан ажилласныг онцлон тэмдэглэж байна.

Төлөөлөгч нөхөд өө!

Монгол улсын Үндсэн хуулийн дагуу энэ онд Улсын Их Хурлын сонгууль болж өнгөрсөн. Хэдийгээр нийслэлийн амьдрал бэрхшээлтэй, эдийн засаг хямралтай байгаа хэдий боловч төр засгийн шинэ тогтолцоог бүрдүүлэхэд нийслэлийн сонгогчид, улс төрийн нийт намууд Улсын Их Хурлын сонгуульд бэлтгэл сайтай, улс төрийн өндөр идэвхжилтэй орж улс төрийн 13 нам, бие даан нэр дэвшигчдээс нийт 88 хүн өрсөлдөж Улсын Их Хуралд 20 гишүүнийг сонголоо.

Нийслэлд Улсын Их Хурлын сонгуулийн 6 тойрог ажилласан бөгөөд тойрог тус бүрд бүртгэгдсэн сонгуулийн насны бүх сонгогчдын 93,9 хувь нь буюу 283132 сонгогч нэр дэвшигчдийнхээ төлөө санаалаа өгч Улсын Их Хурлын гишүүнээ сонгов.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлж нийслэлийн хороо, дүүргийн удирдлагын тогтолцоог байгуулах ажил явагдаж байна. Нутгийн өөрөө удирдах байгууллага болсон Хорооны иргэдийн Нийтийн Хурал болж эдгээрт 16 мянга гаруй иргэд оролцож Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 616 төлөөлөгч сонгогдлоо.

Эдгээр төлөөлөгчдийн дотор улс төрийн II намын төлөөлөгч сонгогдож оролцсон байна. Хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулагдсан II9 хорооны хурал болж Хорооны засаг даргадаа нийт 272 хүний нэрийг дэвшүүлэн хэлэлцэж II8 хүн нь хамгийн олон санал авч Хорооны засаг даргаар нэр дэвшсэн байна.

12 дүүргийн I49 хорооны иргэдийн хурал, Хуулийн дагуу ардчилсан ёс зарчмаар болж өнгөрлөө. Нийслэлийн нийт дүүргийн 616 төлөөлөгчийн төлөө 971, хорооны засаг дарга II9 хүний төлөө 272 хүний нэр дэвшиж хуулинд заасан тооны хүмүүсээ сонгож, дэвшүүдсэн байна.

4.

Хороо, дүүргийн Хурлын Тэргүүлэгчдээр 91 хүний нэр дэвшигдэн хэлэлцэгдэж 76 хүн тэргүүлэгчдээр сонгогдсон байна. Дүүргийн хурлын Тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн даргад улс, нам, олон нийтийн байгууллагын ажилтан 24 хүн сонгогдсон нь дүүргийн еерөө удирдах байгууллагын үйл ажиллагааг жулинд заасан эрх хэмжээнд явуулах боломжтой гэж үзэж байна.

Өнөөдөр дүүргийн Хурлуудаас сонгогдсон төлөөлөгчдөөр бүрдсэн нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдаан хийхээр бид бүхэн цуглараад байна. Мөн энэ хуралдаанд Улсын Их Хурал, Засгийн газрын удирдах нөхөд, харьяа байгууллагын дарга нар, хэвлэл, нийтлэлийн ажилтнууд оролцож байна.

Төлөөлөгч нөхөд өө!

Дүүргийн хурлаас нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд сонгогдсон 72 гишүүнээс тус хуралд 71 төлөөлөгч хүрэлцэн ирээд байна. Өвчтэй 1 хүн хуралдаандаа хүрэлцэн ирж чадаагүй байна.

Хурлын ирц 98,6 хувьтай байна.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 23 дугаар зүйлийн 6-д заасныг үндэслэн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдааны ажиллагаа нээснийг мэдэгдье.

Одоо хуралдааны дарга, нарийн бичгийн дарга нарыг сонгох ажилд орёе.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдааны даргаар Хотын Хянан байцаах албаны дарга төлөөлөгч нөхөр Ж.Хорлоо, нарийн бичгийн даргаар Монгол телевизийн сурвалжлагч Д.Сарангэрлийг сонгох саналыг оруулж байна.

-Өөр саналтай гишүүд байна уу?

-Алга байна.

-Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдааны даргаар төлөөлөгч нөхөр Ж.Хорлоо, нарийн бичгийн даргаар төлөөлөгч нөхөр Д.Сарангэрэл нарыг сонгох саналтай төлөөлөгчид гараа өргөнө үү.

-Болно.

-Татгалзсан, түдгэлзсэн гишүүн байна уу.

-Алга байна.

5.

-Хуралдааны дарга, нарийн бичгийн даргыг санал нэгтэй сонголоо.

Одоо хуралдааны дарга, нарийн бичгийн даргаар сонгогдсон төлөөлөгч нөхөр Ж.Хорлоо, Д.Сарангэрэл нарыг хуралдааны удирдах байранд урьж байна.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН АНХЦУГААР ХУРАЛДААНД МАНДА-
ТЫН КОМИССЫН ТАВЬСАН ИЛТГЭЛ

Илтгэгч нь: Мандатын комис-
сын дарга Г.Маналжав

Төлөөлөгч нөхөд өө!

Монгол улсад өөрчлөлт шинэчлэл эрч хүчтэй явагдаж ардчилсан ёс зарчим хэлбэрэлтгүй хөгжиж байна. Үүний нэг тод идрэл бол Монгол улсын Үндсэн хууль батлагдаж уг хуулийн дагуу Улсын Их Хурлаа сонгож байгуулсан явдал юм.

Мөн Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль батлагдаж орон нутгийн удирдлагын тогтолцоог байгуулах ажил ид явагдаж байна. Энэ бүхэн нь манай орны улс төрийн амьдралд гарч байгаа томоохон үйл явдал, төрт ёс хэлбэрэлтгүй хэрэгжиж Монгол улсын шинэ Үндсэн хуулиа дээдэн хүндэтгэж байгаагийн нэг үр дүн мөн.

Төр Засгийн дээд байгууллага, орон нутгийн удирдлагыг Монгол улсын Үндсэн хуулийн хүрээнд шинээр байгуулж, улс орны хэмжээнд хийгдэж байгаа төрт ёсны энэхүү ажил нь нийслэлд нэгэн адил эрчимтэй хийгдэж байна.

Өнөөдөр хүн ам, хүнс, өргөн хараглазний бараагаар гачигдаж, үнийн огцом өсөлтөд өртөгдөж амьдрал ахуйгаар ядарч байгаа боловч улс орондоо эхэлсэн ардчилал, өөрчлөлт шинэчлэлийг талархан дэмжиж, цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх санаа сэтгэл нэг байгаа нь өнгөрсөн хэдэн сард болж өнгөрсөн үйл явдлууд харуулж байна.

Улсын Их Хурлаа сонгох, нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулах энэ чухал ажилд нийслэлийн иргэд идэвхтэй оролцож байлаа. Энэ чанараараа нийслэлийн иргэд ардчилсан ёс зарчимд суралцаж, төр нийгмийг удирдах хэрэгт ажил хэрэгч, бүтээлч оролцох болсон нь өнөө үеийн нэг онцлог болов.

Хүмүүсийн санаа сэтгэлд эмзэглэсэн асуудал олон, бэрхшээл дутагдал элбэг тохиолдож байгаа боловч тэр бүхнийг даван туулах, хямрал зөрчлөөс богино хугацаанд гарах арга замыг эрэлхийлж, үзэл бодол, үйл ажлаараа тэмцэн улс орноо, нийслэлээ хөгжүүлэх, ахуй амьдралаа сэргээх гэсэн оролдлого санаачлага ч өрнөсөөр байна.

2.

Нийслэлчүүд, сонгосон Удсын Их Хурлын гишүүд, хороо, дүүрэг, нийслэлийн төлөөлөгчиддөө, дэвшүүлсэн Засаг даргадаа их итгэл найдвар, өндөр хариуцлага хүлээлгэж байгааг хэлэхэд илүүдэхгүй.

Тохиолдож байгаа бэрхшээл дутагдлыг арилгаж санаж хүссэнээ богино хугацаанд биелүүлж өгөөсэй гэсэн олон түмний чин сэтгэлийн илэрхийлэл нь бид бүхэнд мөн адил оногдож байгаа үүрэг болно.

✓ Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу нийслэлийн 119 хороо, 12 дүүргийн иргэдийн хурал болж өнгөрлөө. Хуулинд заасны дагуу нутгийн өөрөө удирдах байгууллагууд өргөн олны дундаас сонгогдож өөрийгөө байгуулах, төр засгийн төлөөлөгч Засаг даргадаа нэр дэвшүүлэх хариуцлагатай үүргийг биелүүлж байна.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 7,8 дугаар зүйлд нутгийн удирдлагын тогтолцоо, түүний зарчмыг тодорхойлохдоо: "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн хурал, тухайн хурлын чөлөө цагт түүний Тэргүүлэгчид, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны Засаг даргаас бүрдэнэ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах хууль ёсыг дээдлэх үндсэн зарчим баримтална" гэж заасан билээ.

Энэхүү заалтын дагуу нийслэлийн хороо, дүүргийн өөрөө удирдах байгууллагууд байгуулагдлаа. Энэ байгууллагууд нь Засаг захиргааг нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийг баримтлан сонгогдов. Нийслэлийн хэмжээгээр засаг захиргааны нэгж 119 хороо байгуулагдаж, арван ерх дутмын нэг нь төлөөлөгч оролцсон иргэдийн нийтийн хурлаа хийлээ.

3.

Хороо бүр дүүрэгтээ тав, таван төлөөлөгч сонгож 12 дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал өнгөрсөн долоо хоногт болж өнгөрлөө.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь нийслэлийн хуралд төлөөлөгч сонгох асуудлыг ул суурьтай, хуулинд заасан ёс зарчмыг баримтлан хэлэлцэж шийдвэрлэв. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 5 дугаар заалтанд заасны дагуу нийслэлийн хуралд дүүрэг тус бүр 8-10 мянга хүртэл хүн амтай дүүрэг тус бүр 2 төлөөлөгч сонгохыг заасан юм.

Энэ заалтын дагуу Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгино, Налайх, Багануур дүүрэг тус бүр 8, Багахангай, Гачуурт, Жаргалант, Туул дүүрэг тус бүр 2 төлөөлөгчийг нийслэлийн хуралд сонгов.

Нийслэлийн хуралд сонгогдох 72 төлөөлөгчийн төлөө нийт 137 хүний нэр дэвшигдэн хэлэлцэгдэж хамгийн олон хүний санал авсан 72 хүнээ хуулийн дагуу нийслэлийн хуралд төлөөлөгчөөр сонгожээ.

Нийслэлийн хуралд сонгогдсон төлөөлөгчдийн 80,5 хувь нь буюу 58 төлөөлөгч МАХН-ын гишүүн, 4,1 хувь нь буюу 3 төлөөлөгч МҮДН-ын гишүүд байна. Мөн 15,2 хувь нь буюу 11 төлөөлөгч аль ч намын харьяалалгүй нам бусчууд сонгогджээ.

Нийслэлийн хуралд сонгогдсон төлөөлөгчдийн 11,1 хувь нь буюу 8 нь эмэгтэйчүүд байна. Нийслэлийн эхчүүд, эмэгтэйчүүдийн өмнө тулгарч байгаа эгзэгтэй асуудал бүрийг шийдвэрлэхэд төлөөлөгч эмэгтэйчүүдийн идэвх санаачлага чухал үүрэгтэй. Ер нь эх нялхсын асуудал, хүүхэд залуучуудын хүмүүжил нь эмэгтэйчүүд төдийгүй төлөөлөгч хүн бүрийн санаа сэтгэлийг татсан хури асуудал байх болно.

Нийслэлийн хуралд сонгогдсон төлөөлөгчдийн дотор 26-35 насны залуучууд 19, 36-45 насны хүмүүс 31, 46-55 насны хүн 22, сонгогджээ. Төлөөлөгчдийн насны бүрэлдэхүүн нь амьдралын туршлага, цаг үеийг мэдрэх чадвар, олон түмний санаа сэтгэлийг ойлгох боломж, асуудлыг тал бүрээс нь хэлэлцэх нөхцөл байдлаар боломжтой гэж үзэж байна.

4.

Төлөөлөгчдийн дотор төр, захиргааны ажилтан 40, намын сонгуультаан 10, аж ахуйн нэгжийн удирдлага II, олон нийтийн байгууллагын удирдах ажилтан 2 байна. Мөн сэхээтэн 68, дээд боловсролтой 64, тусгай дунд боловсролтой 4 хүн, эрдмийн зэрэг цолтой хүн 3 байна.

Төлөөлөгчдийн дотор хуульч мэргэжлийн 7, санхүү эдийн засгийн мэргэжилтэй 13, инженер техникийн мэргэжлийн 24, эмч, багш, сэтгүүлч, улс төр судлаач мэргэжлийн 24 хүн сонгогджээ. Хувийн дээд сургуулийн оюутан I хүн сонгогдсон байна.

Төлөөлөгчдийн ажил мэргэжил, боловсролын байдал нь асуудлыг ул суурьтай хэлэлцэж, ажил хэрэгч шийдвэрийг батлан гаргах, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж ажиллахад хангалттай гэж дүгнэх үндэстэй байна.

Хотын ажил амьдралын олон чухал салбарын хүмүүс нийслэлийн хуралд төлөөлөгчөөр сонгогдсон нь өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг амьдрал, олон түмний санаа сэтгэлд ойртуулах, өргөн олонтой байнгын холбоо, харилцаатай ажиллах нөхцлийг бүрдүүлж байна.

Төлөөлөгчдийн дотор халх, казак, буриад, баяд, дарьганга, дөрвөд зэрэг үндэстэн ястан төлөөлөгч сонгогдсон байна. Мөн урьд өмнө Ардын Их Хурал, хот, районы ардын хурлын депутатаар сонгогдож байсан хүмүүс 26 байна.

Төлөөлөгч нөхөд өө!

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд сонгогдсон төлөөлөгчид нь хууль ёсны дагуу нэр дэвшигдсэн, дүүргийн хуралд оролцогчдын хамгийн олон санал авсан хүмүүс сонгогджээ.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн амьдралыг тал бүрээс нь судалж, нухацтай шийдвэрлэх, ардчилал, өөрчлөлт шинэчлэлийг гүнзгийрүүлэн зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих явцыг зүй тогтлын дагуу хөгжүүлэх, нийслэлийн хүн ардын санаа сэтгэл, хүсэл эрмэлзлэлийг бүх талаар илэрхийлэн ажиллаж чадах хүмүүс сонгогдсон байна.

5.

Эдгээр төлөөлөгчид нь нийслэлийн ажил амьдралын олон талт асуудлыг хуулинд заасан бүрэн эрхийн хүрээнд зохион байгуулж, нийслэлийн Засаг даргад дэмжлэг туслалцаа үзүүлэн, хотын хүн амын эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллаж чадах чадвартай хүмүүс байна гэж Мандатын комисс үзэж байна.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн дагуу дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нэр дэвшигдэн хэлэлцэгдэж нууцаар санал хураах замаар хуралд оролцогчдын хамгийн олон санал авч нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гишүүнээр сонгогдсон нэр бүхий 72 хүнийг сонгосон ажил нь хуулийн зохих заалтын дагуу болжээ.

Ийм учраас нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд сонгогдсон 72 гишүүний бүрэн эрхийг зөвшөөрөх саналтай байна.

Та бүхэнд сонгуульд үүргээ биелүүлж, өнөөгийн тулгамдсан асуудлыг зоримог бүтээлч шийдэх их ажилдаа амжилт гаргахыг хүсэн ерөөе.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрч өгөхийг Хурлын хүндэт дарга, эрхэм гишүүд та бүхэнд өргөн мэдүүлж байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААР ДЭВШҮҮЛСЭН
НӨХӨР ЦЭРЭНДЭМБЭРЭЛ ОВОГТОЙ БААСАН-
ЖАВЫН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

н.Баасанжав 1947 онд Төв аймгийн Эрдэнэсант сумын нутагт төрсөн.1965 онд дунд сургууль, 1970 онд МУИС төгссөн, дулааны инженерийн мэргэжилтэй.

Ам бүл 4, эхнэр, хоёр хүүхдийн хамт амьдардаг.МАХН-д гишүүнээр 1974 онд элссэн.

н.Баасанжав 1970-1981 онд хотын Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар байцаагч, инженер, ерөнхий инженер, 1981-1984 онд хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны хэлтсийн дарга,1984-1990 онд хотын Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газрын дарга, 1990 оны 4 дүгээр сараас хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дэд даргаар ажиллаж байна.

н.Баасанжав ОСНААУ газрын даргаар ажиллах хугацаандаа уг байгууллагын зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор районуудад орон сууц ашиглалтын трестийг засвар тохижилтын алба, хэсэгтэйгээр, мөн аваарийн ангийг шинээр байгуулж, аж ахуй зохион байгуулалтын хувьд бэхжүүлжээ.Мөн сантехник, сэлбэг хэрэгслийг өөртөө үйлдвэрлэх, хуучин сэлбэгийг засах ажлыг дотоод нөөц бололцоогоо ашиглан байгуулж, орон сууцны үйлдвэрлэлийн бааз байгуулах, жил бүр орон сууцны нэг хорооллын зургийг гардан хийлгүүлж, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж ажиллаж иржээ.

н.Баасанжав хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дэд даргаар ажиллах хугацаанд орон сууц, дулаан, цахилгаан, усан хангамж, барилга хот тохижилт зэрэг нийтийн аж ахуйн хамгийн эгзэгтэй салбаруудыг хариуцан ажиллаж тэдгээрийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, зах зээлийн нөхцөлд биеэ даан тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч ажиллав.

Нөхөр Ц.Баасанжав нь хот, дүүргийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн шат дамжлага, чирэгдэл, хүнд суртлыг арилгах, талаар байнга анхаарч зарим арга хэмжээг санаачлан хэрэгжүүлж байв.Мөн олон түмэнтэй байнгын холбоотой ажиллах, тэдний санал

хүсэлтийг шуурхай барагдуулах, орон сууц хувиарлах журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх зэргээр ажиллаж байна.

Нөхөр Ц.Баасанжавыг Нийслэлийн Засаг даргад дэвшүүлэх саналыг гаргахдаа доорх шаардлагыг иш үндэс болгож байна.

1.Нөхөр Баасанжав хотын ажил амьдралын эгзэгтэй, хүнд гэгддэг дулаан, цахилгаан, усан хангамж, барилга, орон сууц зэрэг салбаруудын ажлыг удирдаж тэдгээрт тохиолддог саад бэрхшээл, зовлон жаргалыг сайн мэдэх төдийгүй, цаашид юуг хийх, яаж ажиллах чиглэлийг бүрэн ойлгосон, энэ ажилд эртнээс бэлтгэгдсэн боловсон хүчин мөн.

2.Нөхөр Баасанжав нь хотын төр захиргаа, аж ахуйн байгууллагад байцаагчаас эхлээд инженер, ерөнхий инженер, газар, хэлтсийн дарга, захиргааны дэд дарга зэрэг албадуудыг хашихдаа нийслэлийн ажил амьдралын байгууллага, аж ахуйн нэгжийн байрлал, ажлын чиглэл, цаашдын хандлага, хүн амын хүсэл боцлыг сайн мэдэрч, түүний мөрөөр ажиллах хэтийн зорилтоо мэддэг болсон ажилтан юм.

3.Баасанжав нь хотын хүн ам, түүний дотор олон хүүхэдтэй өрх айл, өнчин ядуу хүмүүс, амьдралын төвшингээр доогуур орлоготой иргэдийн ахуй амьдрал, зовлон бэрхшээлийг сайн ойлгож, тэдэнд туслах, энэ үед хэрхэн анхаарах асуудлыг сайн мэдэх хүн юм.

4.н.Баасанжав нь хотын хуралд депутатаар удаа дараа сонгогдон ажиллахдаа өргөн олонтой байнга холбоотой байж, өөрөө удирдах байгууллагыг төрийн удирдлагатай зөв хослон ажиллах арга чадвартай болсон хүн гэж үзэж байна.

5.н.Баасанжав нь ажилд санаачлагатай, зарчимч, нөхөрсөг хамт олон, нөхөддөө халамж анхаарал тавьдаг, ажил хэрэгч, нягт нямбай ажилтан мөн.

ЖИГЖИДСҮРЭНГИЙН ЯЦАМСҮРЭН

Ж.Ядамсүрэн 1950 онд Архангай аймгийн Тариат суманд төрсөн. МУИС, ЗХУ-д нийгмийн ухааны Академи төгссөн. Санхүү эдийн засагч, улс төр, эдийн засгийн ухааны багшийн мэргэжилтэй. Дэд эрдэмтэн, доцент цолтой.

1974-1990 онд намын дээд сургуульд багш, эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1990-1991 онд МАХН-ын ТХ-нд хэлтсийн орлогч эрхлэгч, эрхлэгч, 1991-1992 онд Улаанбаатар хотын МАХН-ын Хорооны дарга, 1992 оны 10-р сараас МАХН-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

БНМАУ-ын АИХ-ын сонгох XII дахь удаагийн сонгуулиар АИХ-ын депутатаар сонгогдож байсан байна.

Харилцах утас 20309
23442

Гарамын Маналжав

Г.Маналжав 1943 онд Завхан аймгийн Завхан-Мандал суманд төрсөн.

1964 онд багшийн сургууль, 1977 онд УБДС төгссөн, багшийн мэргэжилтэй.МАХН-ын гишүүн.

1964-1968 онд Завхан аймгийн Дөрвөлжин, Ургамал сумын сургуульд багш, захирал, 1968-1973 онд Завхан аймгийн ХЗЭ-ийн хороонд зааварлагч, хэлтсийн эрхлэгч, 1977-1981 онд нийслэлийн 7 дугаар сургуулийн захирал, 1981-1987 онд Ажилчины районы Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны хэлтсийн дарга, хариуцлагатай нарийн бичгийн дарга, 1987-1989 онд Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны хэлтсийн дарга, 1989 оноос одоо хүртэл хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Хот, районы Ардын Хурлын депутатаар удаа дараа сонгогдож байсан.

Г.Маналжав^{нб} Хурлын байгууллагын дотоод ажил, Төлөөлөгч, Тэргүүлэгчидтэй ажиллах, Хууль ёсыг хэрэгжүүлэх асуудлыг хариуцах юм.

Харилцах утас 23613

ЛХАМСҮРЭНГИЙН ГАРАМЖИЛ

Л.Гарамжил 1948 онд Завхан аймгийн Сант Маргац суманд төрсөн.

1964 онд Багшийн сургууль, 1976 онд ЗХУ-ын ДЯЯ-ны академийн 4 дүгээр факультетыг, 1988 онд мөн академийн I дүгээр факультетийг тус тус дүүргэсэн.

1964-1967 онд Завхан аймгийн Сантмаргац сумын сургуульд багш, 1967-1971 онд НАХЯ-ны системд гал сөнөөгч, байцаагч, 1976-1981 онд ЦТДС-д багш, тэнхимийн дарга, 1981-1986 онд Дорнод аймаг, Багануурын дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга, 1988 оноос одоо хүртэл хотын Цагдаагийн газрын орлогч даргаар ажиллаж байна.

Хот, районы Ардын Хурлын депутатаар сонгогдож байсан.

Л.Гарамжил нь нийслэлийн Хурлын Тэргүүлэгчдийн хувьд эрх зүйн асуудал, сахилга дэг журам бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг хариуцан ажиллах юм.

Харилцах утас 21947

ЦҮРЭВДОРЖИЙН ГАНБААТАР

Ц.Ганбаатар 1953 онд Улаанбаатар хотод төрсөн. 1976 онд Киев хотын УАААДС, 1990 онд Москва хотын намын дээд сургууль төгссөн. Эдийн засагч, улс төр, судлаачийн мэргэжилтэй. МАХН-ын гишүүн.

1976-1984 онд Улсын төлөвлөгөөний комисст мэргэжилтэн, тасгийн дарга, 1984-1988 онд Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны төлөвлөгөөний комиссын орлогч дарга, 1990-1991 онд МАХН-ын Төв хороонд улс төрийн ажилтан, НТХ-ны даргын эдийн засгийн асуудал эрхэлсэн зөвлөх, 1991 оноос Октябрь дүүргийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга, Баянгол дүүргийн Засаг даргаар ажиллаж байна.

Хот, район Ардын Хурлын депутатаар сонгогдож байсан.

Ц.Ганбаатар, Нийслэлийн Хурлын Тэргүүдэгчдийн хувьд хотын эдийн засаг, нийгмийн асуудал, өмч хувьчлалын хуулийн хэрэгжилтийн байдлыг хариуцах эм.

Харилцах утас 22688

ЛУВСААНЗАМЫН ЦАНШЫМ

Л.Дашням 1943 онд Архангай аймгийн Төвшрүүлэх суманд төрсөн.

1960 онд Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуульд суралцан төгсч, эдийн засаг улс төрийн дээд боловсрол эзэмшсэн. Дэд эрлэмтэн, эрлэм шинжилгээний ахлах ажилтан цолтой.

МУЦН-ын гишүүн. 1967-1972 онд ГЭЗТХУХ, АХУЯ-нд референт. 1972-1978 онд Соёлын яамны хэвлэлийн нэгдсэн редакцид уран зохиолын редактор, 1978-1980 онд ШУА-ийн философи, социологийн эрхийн хүрээлэнд эрлэм шинжилгээний ажилтан, 1980-1983 онд ЗХУ-ын ШУА-ийн Байгалийн шинжлэл, техникийн түүхийн хүрээлэнд аспирант, 1983-1991 онд ШУТУХ, ШУТ-ийн дэвшлийн асуудал судлах төвд мэргэжилтэн, секторын эрхлэгч, 1992 оноос "Монгол мэдлэг"-ийн Их сургуулийн захирлаар ажиллаж байна.

АИХ-ыг сонгох XII дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаас АИХ-ын орлогч даргаар сонгогдон ажиллаж байв.

Л.Дашням Нийслэлийн Хурлын Тэргүүлэгчийн хувьд хотын соёл, шинжлэх ухаан, мэдээлэл, сурталчилгааны асуудал хариуцах юм.

Харилцах утас 22496

61

ГҮНТЭВИЙН ӨЛЗИЙ

Г.Өлзий 1946 онд Увс аймгийн Зүүнговь суманд төрсөн. 1971 онд Уралын политехникийн дээд сургууль, 1986 онд ЗХУ-д аспирантур төгссөн. Хот байгуулалтын инженерийн мэргэжилтэй, Дэд эрдэмтэн. МАХН-ын гишүүн

1971-1977 онд Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд ахлах техник-инженер, зохион байгуулагч, 1977-1988 онд МХЗЭ-ийн Төв Хороонд хэлтсийн эрхлэгч, 1988-1990 онд МАХН-ын Төв Хороонд зохион байгуулагч, группийн ахлагч, 1990-1992 онд хотын МАХН-ын хорооны дэд дарга, 1992 оны 10 дугаар сараас мөн хорооны даргаар ажиллаж байна.

Хот, районы Ардын Хурлын депутатаар сонгогдож байсан.

Г.Өлзий нь нийслэлийн Хурлын тэргүүлэгчийн хувьд хот байгуулалт, байгаль орчныг хамгаалах асуудлыг хариуцах юм.

Харилцах утас 29146

АЮУРЗАНЫН ЦАНЖИД

А.Цанжид 1948 онд Говь-Алтай аймгийн Халиун суманд төрсөн.

~~1973 онд~~ Польш улсад Политехникийн дээд сургууль, НДС, ЗХУ-ын Нийгмийн ухааны академи төгссөн.

Барилгын инженерийн мэргэжилтэй. Дэд эрлэмтэн. МАХН-ын гишүүн.

1973-1974 онд Говь-Алтай аймгийн Барилга угсралтын газрын инженер, 1974-1980 онд мөн аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн дарга, 1982-1991 онд НДС-ийн тасгийн эрхлэгч, 1991 оноос Улс төрийн дээд сургууль, төр нийгэм судлалын академийн улс төрийн социологийн төвийн захирлаар ажиллаж байна.

А.Цанжид нь Нийслэлийн Хурлын Тэргүүлэгчийн хувьд хотын боловсрол, хүүхэд залуучууны хумүүжил, Нийслэлийн хүн амын санаа бодлыг судалж дүгнэлт гаргах асуудлыг хариуцах юм.

Харилцах утас 342272

БАРАМСАЙН ЦЭДЭВ

Б.Цэдэв 1941 онд Баянхонгор аймагт төрсөн. ~~1973 онд~~ МУИС төгсөж, эдийн засгийн мэргэжил эзэмшсэн. МАХН-ын гишүүн 1962-1967 онд Сэлэнгэ аймгийн Гурилын үйлдвэрт цехийн дарга, мастер, 1968-1969 онд Улаанбаатар хотын Гурилын комбинатын орлогч дарга, эдийн засагч, 1982-1987 онд Гурилын үйлдвэрийн орлогч дарга, дарга, 1987-1990 онд Октябрийн районы АХШХ-ны дарга, 1990 оноос хотын Гурилын комбинатын дарга, "Алтан түрүү" компанийн ерөнхий захирлаар ажиллаж байна.

Хот, районы Ардын Хурлын депутатаар сонгогдон ажиллаж байсан.

Б.Цэдэв нь нийслэлийн Хурлын тэргүүлэгчийн хувьд хотын Хүн амын үйлчилгээ, хүнсний хангамжийн асуудлыг хариуцан ажиллах юм.

Харилцах утас 332057

ЖАМБАЛДОРЖИЙН ЭРДЭНЭЧИМЭГ

Ж.Эрдэнэчимэг нь 1959 онд Архангай аймгийн Цэцэрлэг хотод төрсөн.

1987 онд МУИС, 1990 онд Москва хотын НДС төгсөж, багш, улс төр судлаачийн мэргэжил эзэмшжээ. МАХН-ын гишүүн.

1981-1986 онд МУИС-д багш, 1986-1988 онд Сүхбаатарын районы ХЗЭ-ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, 1990 оноос одоо хүртэл хотын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн даргаар ажиллаж байна.

Хот, районы Ардын Хурлын депутат, Хотын АХ-ын Тэргүүлэгч гишүүнээр сонгогдож байсан.

Ж.Эрдэнэчимэг нь Нийслэлийн Хурлын Тэргүүлэгчийн хувьд Хотын хүн ам зүй, эрүүл мэндийн асуудлыг хариуцан ажиллах юм.

Харилцах утас 22913



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ТОГТООЛ

1992 оны 9 дугаар
сарын 23 -ны өдөр

Дугаар I

Улаанбаатар
хот

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын гишүүний бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг шалгасан тухай Мандатын комиссын илтгэлийг хэлэлцээд Улаанбаатар хотын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

"Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн II дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн нийслэлийн дүүргүүдийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдсон хавсралтанд дурдсан нэр бүхий 72 гишүүний бүрэн эрхийг зөвшөөрсүгэй.

ХУРАЛДААНЫ ДАРГА

Ж.ХОРЛОО

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.САРАНГЭРЭЛ

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын анхдугаар хурал-
цааны / дугаар тогтоолын
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ГИШҮҮНЭЭР СОНГОГДСОН ХҮМҮҮ-
СИЙН НЭРС

I. Хан-Уул дүүрэг

- | | |
|------------------------------|---|
| 1. Лодойн Ойдовсамбуу | -Хан-Уул дүүргийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга |
| 2. Чимгээгийн Сангарагчаа | -Хан-Уул дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга |
| 3. Цумбын Энхээ | -52 дугаар сургуулийн багш |
| 4. Алмалигийн Тлейхан | -III цахилгаан станцын дарга |
| 5. Аюурзанын Цанжид | -Төр нийгэм судлалын академийн төвийн захирал |
| 6. Чимэцэрэнгийн Эрдэнэчимэг | -Хивсний үйлдвэрийн эдийн засагч |
| 7. Бацрахын Бямбасүрэн | -Био үйлдвэрийн ерөнхий инженер |
| 8. Чимэддоржийн Энхбат | -МАХН-ын Төв Хорооны ажилтан |

II. Баянзүрх дүүрэг

- | | |
|--------------------------------|---|
| 9. Гүндсамбын Цэрэнбаатар | -Баянзүрх дүүргийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга |
| 10. Лхамсүрэнгийн Гарамжил | -Хотын Цагдаагийн газрын орлогч дарга |
| 11. Цэдэн-Ишийн Болдсайхан | -Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны Хэрэг эрхлэх газрын дарга |
| 12. Үржингийн Хүрэлбаатар | -"Улаанбаатар" сонины ерөнхий эрхлэгч |
| 13. Түдэвийн Билэгт | -Хотын МАХН-ын хорооны өөрийн хяналтын албаны дарга |
| 14. Цэдэнжавын Даваадорж | -Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга |
| 15. Лувсандамбын Дашням | -"Монгол мэдлэг" хувийн цээд сургуулийн захирал |
| 16. Жанчивринчингийн Содмандах | -Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтсийн дарга |

III. Баянгол дүүрэг

- | | |
|-------------------------------|---|
| 17. Пүрэвдоржийн Ганбаатар | -Баянгол дүүргийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга |
| 18. Шагдарын Дашцэрэн | -Хотын Тээврийн газрын дарга |
| 19. Жигжидсүрэнгийн Ядамсүрэн | -Улаанбаатар хотын МАХН-ын хорооны дарга |

20. Жамцын Дашлаваа -Хотын ахмадын хорооны дарга
 21. Бадамраагийн Отгонсүрэн -Хот тохижуулах газрын дарга
 22. Жамбалдоржийн Эрдэнэчимэг -Хотын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга
 23. Цэрэндоржийн Батбаяр -Хувийн дээд сургуулийн оюутан
 24. Гарамын Маналжав -Хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдийн дарийн бичгийн дарга

IV. Сонгино дүүрэг

25. Барамсайн Цэдэв -"Алтан тариа" компанийн захирал
 26. Хандын Магсаржав -Улаанбаатар хотын МАХН-ын хорооны дэд дарга
 27. Даваажанцангийн Сарангэрэл -Монгол телевизийн сурвалжлагч
 28. Жамбын Цэндсүрэн -Улаанбаатар хотын МАХН-ын хорооны газрын дарга
 29. Очирхүрээгийн Тунгалаг -Улаанбаатар хотын Ардын Хурлын Төрийн байгуулалтын хэлтсийн дарга
 30. Гомбожавын Буян-Өлзий -Хотын Эрүүл мэндийн газрын дарга
 31. Мишигийн Чимиддорж -Хотын Боловсролын газрын дарга
 32. Гэээгтийн Хорлоо -16 дугаар эмийн сангийн эрхлэгч

V. Сүхбаатар дүүрэг

33. Гунгаагийн Бүдрагчаа -Сүхбаатар дүүргийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга
 34. Лхамсүрэнгийн Энэбиш -Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга
 35. Цэрэндэмбэрэлийн Баасанжав -Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дэд дарга
 36. Жигмэцийн Хорлоо -Хотын хянан байцаах албаны дарга
 37. Гүнтэвийн Өлзий -Хотын МАХН-ын хорооны дэд дарга
 38. Толмидын Гантөмөр -АУИС-ийн аспирант
 39. Жийлээгийн Базаррагчаа -Сүхбаатар дүүргийн 21 дүгээр хорооны дарга
 40. Наваанзундуйн Ишдорж -Худалдаа үйлдвэрийн яамны газрын дарга

VI. Чингэлтэй дүүрэг

41. Алагийн Зул -Сүхбаатар дүүргийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны орлогч дарга
 42. Содовсүрэнгийн Нармандах -Хөдөлмөрийн яамны газрын дэд дарга

3.

- | | |
|-----------------------------|---|
| 43. Дамдинсүрэнгийн Бямбаа | -ОСНАА-н компанийн захирал |
| 44. Жамсрангийн Чимэгсүрэн | -МОНЦАМЭ агентлагийн хэлтсийн дарга |
| 45. Бямбаагийн Төмөр | -Чингэлтэй дүүргийн 12-р хорооны дарга |
| 46. Чимээгийн Үржээ | -Үндэсний хөгжлийн газрын ажилтан |
| 47. Журамтын Оргил | -Сүхбаатар дүүргийн АХГЗ-ны зохион байгуулагч |
| 48. Цэрэндоржийн Науцагдорж | -Чингэлтэй дүүргийн 10-р хорооны дарга |

VI. Багануур дүүрэг

- | | |
|-------------------------------|--|
| 49. Жигжидийн Хишигт | -Багануурын уурхайн дарга |
| 50. Дондогийн Нямсүрэн | -Багануур дүүргийн РРША цехийн цахилгааны инженер |
| 51. Бэгзжавын Жүгдэр | -Багануур дүүргийн МАХН-ын Хорооны дарга |
| 52. Дамдинсүрэнгийн Дамдин-Од | -Багануур дүүргийн Шүүхийн дарга |
| 53. Боожоогийн Батнасан | -Багануур дүүргийн Зүүнөмнөд районы цахилгаан ШСТ-ын дарга |
| 54. Лувсанвандангийн Дашцэдэн | -Багануур дүүргийн холбооны газрын дарга |
| 55. Батсүхийн Гавьяа-Оролцоо | -Багануур дүүргийн Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дарга |
| 56. Далхсүрэнгийн Сэр-Од | -Багануур дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга |

VII. Налайх дүүрэг

- | | |
|--------------------------|--|
| 57. Чойжилын Жигжидсүрэн | -Налайх дүүргийн Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны дарга |
| 58. Түндэвийн Энхтайван | -Налайх дүүргийн станцын дарга |
| 59. Дашдондогийн Цэнд | -Налайх дүүргийн Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны мэргэжилтэн |
| 60. Дашийн Чулуунбаатар | -Налайхын дүүргийн Зурхайн барилга трестийн дарга |
| 61. Хуандагийн Сауле | -Налайх дүүргийн амаржих газрын ерөнхий эмч |

62. Даваасүрэнгийн Буянтогтох - Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
63. Сандуйжавын Батдорж - Налайх дүүргийн Их уурхайн дарга
64. Дашийн Орги - Налайх дүүргийн МАХН-ын хорооны дарга
- IX. Багахангай дүүрэг
65. Лхамхүүгийн Төмөрхүү - Багахангай дүүргийн АХТЗ-ны дарга
66. Цогтын Батбаяр - Багахангай дүүргийн МАХН-ын үүрийн дарга
- X. Гачуурт дүүрэг
67. Лхамжавын Буянт - Гачуурт дүүргийн МАХН-ын үүрийн дарга бөгөөл соёл мэдээлэл хүмүүшлийн төвийн эрхлэгч
68. Далхын Дэлэгням - Гачуурт дүүргийн ерөнхий мал зүйч
- XI. Туул дүүрэг
69. Адъяагийн Шархүү - Баянтал хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга
70. Дашдондогийн Пүрэвдорж - "Бөхөг" компанийн захирал
- XII. Жаргалант дүүрэг
71. Сандагийн Ядам - Жаргалант дүүргийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга
72. Доржийн Бадарч - Жаргалант дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ТОГТООЛ

19 92 оны 9 дугаар
сарын 23 -ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар
хот

Сонгуулийн комисс байгуу-
лах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дүгээр заалтыг үндэслэн Улаанбаатар хотын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн дарга, тэргүүлэгч гишүүдийг сонгох, Засаг даргад нэр дэвшүүлсэн саналыг хураах, тоолох, дунг гаргах сонгуулийн комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

- | | |
|------------------|--|
| 1. Ч.Эрдэнэчимэг | -Хан уул дүүргийн төлөөлөгч, Хивсний Улаанбаатар компанийн ерөнхий инженер |
| 2. Ж.Содмандах | -Баянзүрх дүүргийн төлөөлөгч, мөн дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга |
| 3. С.Ядам | -Жаргалант дүүргийн төлөөлөгч, мөн дүүргийн АХ-ын гүйцэтгэх захиргааны дарга |
| 4. М.Чимиддорж | -Сонгино дүүргийн төлөөлөгч, хотын Боловсролын газрын дарга |
| 5. Г.Буян-Өлзий | -Сонгино дүүргийн төлөөлөгч, хотын Эрүүл мэндийн газрын дарга |
| 6. Д.Нямсүрэн | -Багануур дүүргийн төлөөлөгч, дүүргийн РРША цехийн инженер |
| 7. Т.Энхтайван | -Налайх дүүргийн төлөөлөгч, дүүргийн станцын дарга |

ХУРАЛДААНЫ ДАРГА

Ж.ХОРЛОО

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.САРАНГЭРЭЛ



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ТОГТООЛ

19 92 оны 9 дугаар
сарын 23 -ны өдөр

Дугаар 3

Улаанбаатар
хот

Нийслэл
Нийтийн иргэдийн төлөөлөгч-
дийн хурлын тэргүүлэгчдийн
даргыг сонгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,
түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 4 дүгээр
заалтыг үндэслэн Улаанбаатар хотын Иргэдийн төлөөлөгчдийн
хурлын анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Улаанбаатар хотын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүү-
лэгчдийн даргаар Жигжидсүрэн овогтой Ядамсүрэнг сонгосугай.

ХУРАЛДААНЫ ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ж.ХОРЛОО

Ц.САРАНГЭРЭЛ



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ТОГТООЛ

1992 оны 9 дугаар
сарын 23 -ны өдөр

Дугаар 4

Улаанбаатар
хот

Тэргүүлэгчдийн нарийн бичгийн
даргыг сонгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 4 дүгээр заалт, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн 100 хувийн саналыг үндэслэн Улаанбаатар хотын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Улаанбаатар хотын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Гарам овогтой Маналжавыг сонгосугай.

ХУРАЛДААНЫ ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ж.ХОРЛОО

Д.САРАНГЭРЭЛ



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ТОГТООЛ

19 92 оны 9 дугаар
сарын 23 -ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар
хот

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгч-
дийн хурлын тэргүүлэгчдийг
сонгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 4 дүгээр заалтыг үндэслэн Улаанбаатар хотын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Улаанбаатар хотын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийг доорх бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:

1. Жигжидсүрэнгийн Ядамсүрэн
2. Гарамын Маналжав
3. Жамбалдоржийн Эрдэнэчимэг
4. Гүнтэвийн Өлзий
5. Барамсайн Цэдэв
6. Аюурзанын Цанжид
7. Пүрэвдоржийн Ганбаатар
8. Лхамсүрэнгийн Гарамжил
9. Лувсандамбын Дашням

ХУРАЛДААНЫ ДАРГА

НАРИЙН БИЧИЙН ДАРГА

Ж. ХОРЛОО

Д. САРАНГЭРЭЛ



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ТОГТООЛ

1992 оны 9 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

Нийслэлийн Засаг даргад нэр
дэвшүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн Улаанбаатар хотын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын гишүүдийн 100 хувийн саналаар нийслэл Улаанбаатар хотын Засаг даргад Цэрэндэмбэрэл овогтой Баасанжавын нэрийг дэвшүүлсүгэй.

2. Цэрэндэмбэрэл овогтой Баасанжавыг Нийслэлийн Засаг даргаар томилж өгөхийг Монгол Улсын Засгийн Газрын Ерөнхий сайдад хүссүгэй.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН ДАРГА

Ж. Ядамсүрэн Ж.ЯДАМСҮРЭН

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г. Маналжав Г.МАНАЛЖАВ



Б Н М А У

УЛААНБААТАР, ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

1992 оны 9 дугаар
сарын 25-ний өдөр

№ 05

Улаанбаатар хот—11

Утас 25976

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн нарийн
бичгийн дарга нарыг ажил-
луулах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч-
дээс ТОГТООХ нь:

I. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 4 дүгээр заалт, Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн И.Лхамсүрэнг, Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 04 дүгээр тогтоолыг үндэслэн Ц.Цаваадоржийг, Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 3 дугаар тогтоолыг үндэслэн Х.Төмөрийг, Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн Х.Булганыг, Сонгино дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн Ц.Дамдинпүрэвийг, Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн Ж.Дангааг, Гачуурт дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 04 дүгээр тогтоолыг үндэслэн Ц.Болдыг, Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн Ц.Сэр-Одыг, Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 3 дугаар тогтоолыг үндэслэн Д.Буянтогтохыг, Жаргалант дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг үндэслэн Ц.Баларчийг, Туул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 3-р тогтоолыг үндэслэн Ц.Алтангэрэлийг, Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн Ч.Оюунчимэгийг 1992 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс тус тусын дүүргийн Иргэдийн

Төлөөлөгчлийн Хурлын Тэргүүлэгчлийн нарийн бичгийн даргаар ажиллуулсугай.

2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчлийн Хурлын Тэргүүлэгчлийн нарийн бичгийн дарга нарын сарын цалинг 2100-2400 төгрөгөөр тогтоож 1992 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн цалинжуулахыг дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.

1037



МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭГЖҮҮ-
ЛЭГЧИЙН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТӨЛӨӨЛӨГЧИЙН ДАРГА

[Handwritten signature]

Ж. ЯДАНСҮРЭН

[Handwritten signature]

Г. МАНАЛЖАВ

[Handwritten signature]

Ц. ГАНБААТАР

[Handwritten signature]

Л. ГАРАМШИЛ

[Handwritten signature]

Л. ДАННЯМ

[Handwritten signature]

С. ӨЛЗИЙ

[Handwritten signature]

Ц. ЦАГЖИД

[Handwritten signature]

Б. ЦЭЦЭВ

Х. ЭРДЭНЭЧИМЭГ



Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгч-
 Хурлын Төргүүлэгчдийн 1992
 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
 12 дугаар тогтоолоор батлав. *127*

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
 ХУРЛЫН АЖЛЫН ХЭСҮҮДИЙН АЖИЛЛАХ
 ЧИГЛЭЛ, АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Нэг. Нийтлэг зорилго

1. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэн хурлын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хурлын гишүүдийг зорилго чиглэлтэй ажиллуулж, сонгуульт үүргээ биелүүлэхэд нь туслах, нийслэлийн эдийн засаг, нийгмийн амьдралын олон талт асуудлыг чиглэл чиглэлээр хариуцан нутгийн өөрөө удирдах байгууллагын нэрийн өмнөөс ажиллах зорилгоор хурлын гишүүдийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулж байгаа юм.

2. Ажлын хэсгүүд нь хариуцсан салбарын чиглэлээр асуудлыг судалж боловсруулах, шалгаж танилцах замаар дүгнэлт гаргах, гарч байгаа буюу болзошгүй дутагдал бэрхшээлийг арилгах, Хурал, Төргүүлэгчдийн хуралдаанд асуудал боловсруулж хэлэлцүүлэх, гаргасан шийдвэрийг сурталчилж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлт, үр дүнг хянаж шалгах зэргээр ажиллана.

3. Хурал нь өөрөө удирдах байгууллага болох учраас "Ажлын хэсэг"-т нийслэлийн нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа эрдэмтэд, мэргэжлийн сэхээтнүүд, эмчийн олон хэвшилт аж ахуйн нэгжийн ажилтан, иргэдийн төлөөлөгчдийг өргөн оролцуулж эгнээгээ өргөтгөн үйл ажиллагаагаа явуулахыг эрхэмлэнэ.

4. Ажлын хэсгүүд нь хариуцсан чиглэлийн салбарын хамт олонтой уулзаж ярилцах, ажил байдалтай нь танилцах, төрийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах, салбарын хамт олноос болон тухайн чиглэлээр гарсан санал, санаачлага, өргөдөл гомдлыг шалгаж шийдвэрлэхэд бие даан ажиллана.

5. Ажлын хэсгүүд нь Монгол улсын үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох хуулийн хүрээнд хариуцсан ажлын чиглэлээр төр, олон нийт, хууль хяналт, цагдаа, эрдэм шинжилгээний байгууллагуудтай

болон "Ажлын хэсэг"-үүд хамтран ажиллаж асуудлыг тал бүрээс нь судлан шинжлэх, ул суурьтай дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулахад анхаарч ажиллана.

Хоёр. Сахилга дэг журам бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хэсэг:

1. Нийслэлийн хэмжээнд сахилга дэг журам тогтоох, нийгмийн хэв журам хамгаалах, иргэдийн хууль ёсны эрхийг хангах, эрх зүйн хүмүүжлийг дээшлүүлэх талаар бодлого боловсруулах, энэ чиглэлээр холбогдох байгууллага, албадаас зохиож байгаа ажлыг шалгаж танилцах.

2. Хотын нутаг дэвсгэрт эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн төсөл, төр, нийгмийн амьдралын чухал асуудлыг ард нийтээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах ажлыг зохион байгуулж дүгнэлт гаргах.

3. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн биедэлт, иргэдийн санал, өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулах, биелэлтэнд хяналт тавих.

4. Төрийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах, энэ чиглэлээр ажил үүрэг хүлээсэн байгууллага, хүмүүсийн ажлыг чиглүүлэх, судалгаа дүгнэлт гаргах, иргэд хөдөлмөрчидтэй уулзаж ярилцах, санал боловсруулах.

Тус ажлын хэсгийн хариуцан ажиллах байгууллагууд:

1. Хотын цагдаагийн газар
2. Хотын прокурор
3. Хууль зүйн газар
4. Хяналтын байгууллагууд

Гурав. Соёл, шинжлэх ухаан, боловсрол, мэдээлэл сурталчилгааны асуудал эрхэлсэн ажлын хэсэг

1. Төр, захийн бодлого, хууль тогтоол, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг сурталчлах, хотын амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хийгдэж буй хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх талаар санал боловсруулах.

3.

2. Нийслэлийн хөдөлмөрчдөд соёлын үйлчилгээг ойртуулах, соёл, урлагийн байгууллагуудын ажил, үйлчилгээний талаар санал дүгнэлт боловсруулах.

3. Хотын хөдөлмөрчдийн дунд соёл олон түмний ажлыг чиглүүлэх, тодорхой чиглэлээр ярианы сэдэв, лекц боловсруулж сурталчлах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

4. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж нийслэлийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг сурталчлах чиглэлээр нийтлэлийн бодлогыг чиглүүлэх, үр дүн, явцад нь хяналт тавих.

5. Хотыг хөгжүүлэх, тохиолдож байгаа бэрхшээлээс гарах арга замыг судалж боловсруулан санал дүгнэлт гаргахад нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа шинжлэх ухааны байгууллагуудын хүч анхаарлыг чиглүүлэх.

6. Боловсролын системийг боловсронгуй болгох, нийслэлийн хүүхдийн хүмүүжил, боловсролыг дээшлүүлэх асуудлыг судалж санал санаачлага гаргах.

Тус ажлын хэсгийн хариуцан ажиллах байгууллагууд:

1. Шинжлэх ухаан, боловсролын газар
2. Хотын соёлын хэлтэс
3. Улаанбаатар сонинны газар
4. Улаанбаатар телевиз
5. Радиогийн Улаанбаатарын нэвтрүүлгийн редакци.

Дөрөв. Хот байгуулалт, байгаль орчныг хамгаалах асуудал эрхэлсэн ажлын хэсэг:

1. Хот байгуулалт, төлөвлөлтийн байдал, түүний хэрэгжилтэнд дүгнэлт хийж, энэ талаар хөдөлмөрчдөөс гаргасан санал, хүсэлтийг судлах.

2. Хотын байгаль орчныг унаган төрхөөр нь хадгалах, экологийн тэнцвэртэй байдлыг хангах, нийслэлийн хөдөлмөрчдийг байгаль хамгаалах, хот орчноо цэвэр байлгах үйлсэд оролцуулах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

3. Хотын экологийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх талаар холбогдох газруудад санал тавих, энэ чиглэлээр гарч байгаа ажлын

дэвшилтэт арга хэлбэрийг сурталчлах, нийтийн хүртээл болгоход анхаарч ажиллах.

4. Газар эзэмшлийн байдалд хяналт тавьж, илэрсэн дутагдлыг арилгах, гарч байгаа бэрхшээлийг даван туулах чиглэлийг суулах.

5. Захын хорооллын суурьшил, тэнд нийгмийн асуудлыг шийдвэрлэх нөхцөл боломжийг судалж, холбогдох байгууллага, албан тушаалтны хүч анхаарлыг чиглүүлэх.

6. Хотын зам талбайн ашиглалт, засвар үйлчилгээ, тохижилтын ажлын явцад хяналт тавих, иргэдийн санал бодлын дагуу чиглэл өгөх.

Тус ажлын хэсгийн хариуцан ажиллах байгууллагууд:

1. Хот төлөвлөлтийн газар
2. Барилга хөрөнгө оруулалтын газар
3. Хот тохижуулах газар
4. Хотын БОХ газар
5. Хотын ойн аж ахуй
6. Богд уулын захиргаа
7. Зам барилга ашиглалтын трест
8. Хотын барилгын байгууллагууд

Тав. Хүүхэд, залуучуудын асуудал, нийслэлийн хүн амын хүсэл бодол, санаа сэтгэлийг судлах, дүгнэлт гаргах ажлын хэсэг:

1. Хүүхэд, залуучуудын хүмүүжил, ажил эрхлэлтийн байдалд судалгаа явуулж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын чиглэл боловсруулах.

2. Нийслэл хотын нутаг дэвсгэрт хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, үндэсний өв уламжлалаас зааж сургах, нийтийн биеийн тамирын зохистой хэлбэрийг хөгжүүлэх талаар холбогдох байгууллагуудад асуудал тавьж хамтран ажиллах.

3. Нийслэлийн ажил амьдралын тулгамдсан асуудлаар иргэдийн санал бодлыг холбогдох байгууллагуудтай хамтран судалж санал, дүгнэлт боловсруулах, түүний мөрөөр зохиох ажлыг хянаж шалгах.

4. Хүүхэд залуучуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэднийг зах зээлийн эдийн засгийн харилцаанд бэлтгэж сургах, бие даан

ажил амьдралаа зохион байгуулах арга барилд сургах чиглэлийг судалж боловсруулах, энэ чиглэлээр хийж байгаа ажлыг сайжруулахад тус дэм үзүүлэх.

Тус ажлын хэсгийн хариуцаж ажиллах байгууллагууд:

1. Хотын боловсролын газар
2. Хотын хүүхдийн байгууллага
3. Хотын залуучуудын холбоо
4. Хотын залуучууд спортын хороо
5. Хотын цагдаагийн газар
6. "Итгэл" төв

Зургаа. Хүн ам зүй, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн ажлын хэсэг:

1. Улаанбаатар хотын хүн амын эрүүл мэндийг хамгаалах тухай асуудал хэлэлцсэн хотын Ардын Хурлын 16 дахь удаагийн сонгуулийн III чуулганы шийдвэр, "Эрүүл мэндийн хөтөлбөр"-ийн биелэлтэнд хяналт тавьж хэрэгжүүлэх.

2. Нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдалд судалгаа хийж, ажлын нэмэгдэл байр бий болгох, ажиллагсдын хөдөлмөр хамгаалалтын байдалд хяналт тавих чиглэлээр бодлого боловсруулах.

3. Өндөр настан, тахир дутуу иргэд, сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүс, амьдралын гачигдалтай, өнчин, хагас өнчин хүүхдүүд зэрэг нийгмийн халамж шаардах иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд боломж нөхцлийг судлах, энэ чиглэлээр хот, дүүргийн Засаг дарга нараас хийж байгаа ажилтай танилцаж эрчимжүүлэх.

4. Хотын хүн ам зүйн бодлого боловсруулах, гоц аюултай өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах.

Тус ажлын хэсгийн хариуцаж ажиллах байгууллагууд:

1. Хотын эрүүл мэндийн газар
2. Хөдөлмөрийн хэлтэс
3. Хотын АЦХХ станц
4. Хотын эмэгтэйчүүдийн зөвлөл

6.

Долоо. Нийгэм, эдийн засгийн асуудал эрхэлсэн ажлын хэсэг

1. Нийслэлийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр, төслүүдэд иргэдийн санал хүсэлтийг тусгах, тэдгээрийн бие-лэлтэнд хяналт тавих.

2. Нийслэл хотын хэмжээнд төсвийн хуваарилалт, татварын албаны ажил үүрэг, санхүү бүртгэлийн хөтөлбөрт хяналт тавьж, хөдөлмөрчдийн санал бодлыг судлах, хэрэгжүүлэх чиглэлээр ажил-лах.

3. Төсвийг арвиц хямгач, үр ашигтай зарцуулах, орлогын нэ-мэгдэл эх үүсвэр олох, албан татварын хуулийг биелүүлэх ажилд хяналт тавих.

4. Нийслэлийн хэмжээнд өмч хувьчлалын ажил хэрхэн яваг-даж байгааг хяналт тавьж, хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах.

5. Нийгмийн баялгийг нэмэгдүүлэх талаар нийслэл хотын үйлд-вэр, албан байгууллага, иргэдийн хүч бололцоог дайчлан ажиллах чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг чиглүүлэх.

Тус ажлын хэсгийн хариуцаж ажиллах байгууллагууд:

- 1. Нийгэм, эдийн засгийн бодлогын зөвлөл
- 2. Санхүүгийн хэлтэс
- 3. Албан татварын алба
- 4. Хотын банкны контор

Найм. Хүн амын үйлчилгээ, хүнсний хангамжийн асуудал эрхэл-сэн ажлын хэсэг.

1. Нийслэлийн хүн амын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, хөдөлмөрчдөөс энэ салбарын талаар гаргасан санал хүсэлтийг судалж шийдвэрлэх.

2. Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор нийс-лэлийн үйлдвэр, албан байгууллага, компани, ХЭАА, гадаад дотоо-дын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, тэдний ажилд туслалцаа үзүүлэх нөөц бололцоог ашиглах ажлыг зохион байгуула-хад тус дэм үзүүлэх санал, санаачлага гаргах,

3. Үйлчилгээний байгууллагуудын тасралтгүй ажиллагааг хангах хөдөлмөрчдөд үйлчилгээг оортуулах чирэгдлийг багасгах чиглэлээр бодлого, чиглэл боловсруулж ажиллах, энэ чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг илэвжүүлж чиглүүлэх,

7.

4. Хүн амын санал бодлыг байнга судалж тэр чиглэлээр Хурлын байгууллагаас хийх ажлыг санаачлах,

Тус ажлын хэсгийн хариуцаж ажиллах байгууллагууд:

1. ХААХҮУ Газар

2. Худалдаа хоолны ерөнхий компани

3. ОСНАА компани

4. Хотын тээврийн газар

5. Ус сувгийн ашиглалтын газар

6. Хүнсний болон барааны зах

7. Цахилгаан шугам сүлжээний газар

8. Дулааны шугам сүлжээний газар

9. Телефон холбооны газар

10. Радио сүлжээний газар



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

11

1992 оны 12-р сарын 2 өдөр

№ 12

Улаанбаатар хот—11
Утас 25976

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг ажлын хэсгүүдэд хуваарилан, тэдгээрийн ажиллах чиглэлийг батлах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлж, хурлын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хурлын гишүүдийг зорилго, чиглэлтэй ажилдуулж, сонгуульт үүргээ биелүүлэхэд нь туслах зорилгоор нийслэлийн Хурлын Төлөөлөгчдийг ажлын хэсгүүдэд хуваарилан ажилдуулсугай.

2. Ажлын хэсгүүдийн ажиллах чиглэл, ажил үүргийн хуваарийг баталсугай.

3. Ажлын хэсгүүдээс хариуцсан салбарын чиглэлээр ажиллахад шаардлагатай туслалцааг үзүүлж, чиглэл удирдамжаар ханган тэдгээрийн ажлыг хагас бүтэн жилээр дүгнэж ажиллахыг Хурлын ажлын алба /н.Тунгалаг/-нд цаалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН НАРИЙН БИЧИЙН ДАРГА

[Signature] Ж.ЯДАМСҮРЭН

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН НАРИЙН БИЧИЙН ДАРГА

[Signature] Г.МАНАЛЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД

[Signature] П.ГАНБААТАР
[Signature] Л.ГАРАМЖАЛ
[Signature] Н.ДАШБТИ
[Signature] Г.ӨСӨЛ
[Signature] А.ЦАМЦА
[Signature] В.ЦЭДЭВ
[Signature] В.ЭРДЭНЧИМЭГ



Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1992 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 12-р тогтоолоор батлав.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ АЖЛЫН ХЭСГҮҮ-ЦЭД ХУВААРИЛСАН ХУВААГЬ

Сахилга дэг журам бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хэсэг

- 1. Л. Гарамжил - /ахлагч нь/ Хотын цагдаагийн газрын орлогч дарга
- 2. Ж. Базаррагчаа - Сүхбаатар дүүргийн ОСГ-ны хорооны дарга
- 3. Ц. Болдсайхан - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
- 4. Д. Дамдин-Од - Багануур дүүргийн шүүхийн дарга
- 5. Ч. Сангарагчаа - Хан-Уул дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга
- 6. Ж. Содмандах - Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга
- 7. О. Тунгалаг - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дарга
- 8. Т. Энхтайван - Налайх дүүргийн Дулааны станцын дарга
- 9. С. Ядам - Жаргалант дүүргийн Засаг дарга

Нийгэм, эдийн засгийн асуудал эрхэлсэн ажлын хэсэг

- 1. П. Ганбаатар - /ахлагч нь/ Баянгол дүүргийн Засаг дарга
- 2. Ц. Батбаяр - Багахангай хорооны МАХН-ын үүрийн дарга
- 3. С. Батдорж - Налайхын уурхайн дарга
- 4. Б. Бямбасүрэн - Био үйлдвэрийн эдийн засагч
- 5. Д. Дэлэгням - Гачууртын САА-н ерөнхий мал зүйч
- 6. Х. Магсаржав - Улаанбаатар хотын МАХН-ын хорооны дэд дарга
- 7. Д. Нямсүрэн - Багануурын РРША цехийн цахилгааны инженер
- 8. Н. Ицдоржиев - ХҮЯ-ны газрын дарга
- 9. Л. Ойдовсамбуу - Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан
- 10. Д. Пүрэвлорж - "Бөхөг" компанийн захирал
- 11. Ж. Цэндсүрэн - Сонгино дүүргийн Засаг дарга

Соёл, шинжлэх ухаан, боловсрол, мэдээлэл суртал-чилгааны асуудал эрхэлсэн хэсэг

- 1. Л. Дашням - /ахлагч нь/ "Монгол мэдлэг" хувийн дээд сургуулийн захирал
- 2. Б. Жуглар - Багануур дүүргийн МАХН-ын хорооны дарга

3. Ү. Хүрэлбаатар - "Улаанбаатар" тусгай ерөнхий эрхлэгч дарга
 4. Ж. Чимэгсүрэн - "Мончамэ" агентлагийн хэлтсийн дарга
 ✓ 5. Д. Цэнл - Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан
 6. А. Шархүү - Туул дүүргийн Засаг дарга
 7. Ц. Энхээ - 52-р сургуулийн багш
 8. Ч. Энхбат - МАХН-ын Төв Хорооны ажилтан
 9. Ч. Эрдэнэчимэг - Хивсний Улаанбаатар компанийн ерөнхий инженер

Хот байгуулалт, байгаль орчныг хамгаалах асуудал эрхэлсэн ажлын хэсэг

1. Г. Өлзий - /ахлагч нь/ Улаанбаатар хотын МАХН-ын Хорооны дарга
 2. Т. Билэгт - Хан-Уул дүүргийн Засаг дарга
 3. Ц. Батбаяр - Хувийн дээд сургуулийн оюутан
 4. Л. Дашцэдэн - Багануур дүүргийн холбооны дарга
 5. Ц. Даваадорж - Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
 6. А. Зул - Чингэлтэй дүүргийн Засаг дарга
 7. Б. Отгонсүрэн - Хот тохижуулах газрын дарга
 8. Ж. Хишигт - Багануурын уурхайн дарга
 9. Д. Чулуунбаатар - Налайхын уурхайн барилга трестийн дарга

Боловсрол, хүүхэл залуучуудын асуудал, Нийслэлийн хүн амын хүсэл болол, санаа сэтгэлийг судлах дүгнэлт гаргах асуудал эрхэлсэн ажлын хэсэг

1. А. Цанзид - /ахлагч нь/ Төр нийгэм судлалын академийн төвийн эрхлэгч
 2. Ж. Дашлаваа - Хотын ахмадын хорооны дарга
 3. Б. Гавъяа-Оролцоо - Багануур дүүргийн Засаг дарга
 4. Ц. Нацагдорж - Чингэлтэй дүүргийн ОСГ-ны хорооны дарга
 5. Ч. Жигжидсүрэн - Налайх дүүргийн Засаг дарга
 6. Б. Буянт - Гачуурт дүүргийн МАХН-ын үүрийн дарга
 7. Ж. Оргил - Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан
 8. Д. Сарангэрэл - Монгол телевизийн ажилтан
 9. М. Чимэддорж - Хотын боловсролын газрын дарга

Хүн амын үйлчилгээ, хүнсний хангамжийн асуудал
ЭРХЭЛСЭН АЖЛЫН ХЭСЭГ

- 1. Б.Цэдэв -/ахлагч нь/ "Алтан түрүү" компаний ерөнхий захирал
- 2. Б.Батнасан -Багануурын Зүүн өмнөл районы ЦШС-ны газрын дарга
- 3. Д.Бямбаа -Нийслэлийн Засаг даргын орлогч
- 4. Ш.Дашцэрэн -Хотын тээврийн газрын дарга
- 5. Д.Буянтогтох -Надайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- 6. Б.Төмөр -Чингэлтэй дүүргийн ОСГ-ны хорооны дарга
- 7. Л.Төмөрхүү -Багахангай дүүргийн Засаг дарга
- 8. А.Төлейхан -Ш цахилгаан станцын дарга
- 9. Д.Сэр-Од -Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- 10. Ж.Хорлоо -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хянан байцаах хэлтсийн дарга
- 11. Г.Цэрэнбаатар -Баянзүрх дүүргийн Засаг дарга

Хүн ам зүй, эрүүл мэндийн асуудал
ЭРХЭЛСЭН АЖЛЫН ХЭСЭГ

- 1. Ж.Эрдэнэчимэг -/ахлагч нь/ Хөдөлмөрийн яамны газрын дарга
- 2. Д.Бадарч -Жаргалант дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- 3. Г.Будрагчаа -Сүхбаатар дүүргийн Засаг дарга
- 4. Т.Гантөмөр -АУИС-ийн аспирант
- 5. Г.Буян-Өлзий -Хотын Эрүүл мэндийн газрын дарга
- 6. Х.Сауле -Надайх дүүргийн нэгдсэн эмнэлгийн амч
- 7. С.Нармандах -Хөдөлмөрийн яамны газрын дэд дарга
- 8. Ч.Үржээ -Үндэсний хөгжлийн газрын ажилтан
- 9. Г.Хорлоо -16-р эмийн сангийн эрхлэгч
- 10. Д.Орги -Надайх дүүргийн МАХН-ын хорооны дарга



1992 ОНЫ НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АНХДУГААР СОНГУУЛИЙН СОНГОГЧДЫН СТАТИСТИК МЭДЭЭ

